

2004 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ, БОДИТ БАРИМТ БА УЧИР ШАЛТГААН

Удо Б. Баркманн

Монгол Улсын Их Сургууль. Монгол Судлалын Төв.

Өгүүлэлийн товч утга: Энэхүү өгүүлэлд 2004 оны УИХ-ын сонгуулийн үйл явц, үр дүнд шинжилгээ хийж, улмаар Монголын улс төрийн намуудын төлөвшлийн өнөөгийн төрх байдлаас улбаатай хүчин зүйлс тус улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд хэрхэн нөлөөлж байгаа тухай баримт түшин өгүүлэх болно.

Түлхүүр үг: 2004 оны УИХ-ын сонгууль, Монголын улс төрийн намуудын дүр төрх, хүчний харьцаа, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, шинэ сонголт.

Улсын Их Хурлын 2000 оны сонгууль

2000 оны 07 сарын 02¹-нд болсон УИХ-ын сонгуулиар МАХН хүчинтэй саналын 51,6 %-ийг авч итгэл дүүрэн ялалт байгуулан парламентын 76 суудлын 72-ыг нь авч УИХ-д орсноор олон Монголчууд сэтгэл амрах мэт болсон юм. Учир нь "Ардчилсан Холбоо" Эвслийн Засгийн газар эрх барьж байсан сүүлийн жилүүдэд тус орон хүнд хямралыг туулахад хүрсэн билээ. Эдийн засаг зогсонги байдалд орж, төрийн ба төсвийн дэг журам алдагдаад байлаа. Төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 12%-д хүрч, инфляцийн хэмжээ дахин хоёр оронтой тоонд хэлбэлзэх болов.² Монголын хандивлагчид Засгийн газрыг бодлогыг эрс шүүмжлэв. Олон Улсын Валютын Сан Монголд үзүүлэх тусламжаа бүр зогсоосон юм. МАХН-ын сонгуулийн ялалт шинэ эхлэлийн дохио боллоо. Олон Монголчууд, түүний дотор МАХН-ын дэмжигчид болоод шүүмжлэгчид энэ туршлагатай, боловсон хүчинтэй намд улс орныг удирдах илүү чадвар бий хэмээн итгэл үзүүлэв.

МАХН-ын Засгийн газрын эдийн засгийн тогтворжуулалт (2000-2004)

Ерөнхий сайд Н. Энхбаярын удирдсан МАХН-ын Засгийн газар эдийн засаг, санхүүгийн бодлогыг үйл ажиллагааныхаа хамгийн чухал талбар болгон тодорхойлж, ажилдаа шуурхайлан орсон юм. Засгийн газар улсын төсвийг цэгцэлж, түүний зарлагын сахилга батыг чангатгав. Төсөв эрүүлжих эхний чиг хандлага гарч, 2002 оны эцэс гэхэд төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 5% хүртэл багасав. Мөн дурьдалгүй өнгөрч үл болох нэг хүчин зүйл нь 2000-2002 онуудад болсон байгалийн гамшигт (ган, зуд) тус орны эдийн засгийн хамгийн чухал салбар болох мал аж ахуйн салбар нэрвэгдэж, их хэмжээний мал хорогдсон явдал байлаа. Жишээлбэл, Говь-Алтай аймаг л гэхэд 2002 онд нийт малынхаа 38,2% (658.700) алдсан юм. 9.239 малчин өрхийн 1.096 нь амьдралынхаа эх үүсвэрийг бүрэн алдсан байлаа.

Монгол Улсын малын тоо толгой

1999	2000	2001	2002	2003
33.568.900	30.227.500	26.075.300	23.897.600	25.427.700

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэл, Улаанбаатар 2003, 2004

МАХН улсын төсвийн бүтцийг шинэчлэхээр тогтож, УИХ 2002 онд "Нэгдсэн төсвийн тухай хууль" болон "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль"-ийг баталсан юм³. Эдгээр хуулиуд нь санхүүгийн

¹ U. B. Barkmann, Politische Parteien und demokratischer Prozess in der Mongolei, in Mongolische Notizen – Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft e.V. 12(2003), хуудас 24-43.

² Г. Отгонбаяр, Монголчууд гарман дээр морио юүлдэггүй, Зууны Мэдээ, 2002.10.23.

³ 2002.11.20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл,

системийг нилээд төвлөрүүлсэн боловч эерэг болоод сөрөг үр дагавар дагуулав. Төрийн санхүүжилтийг төвлөрүүлэн шийдвэрлэж байх боломж Засгийн газарт бүрдлээ. Аймгуудын төсвийн сахилга батгүй байдал, жилийн дунджаар 30-35 хүртэл сая ам. долларын зээлийн өртэй Монгол Улсын хувьд энэ бол зохицуулалт байлаа. Засгийн газар эрх зүйн энэхүү зохицуулалтаар Шинэтгэлийн үйл явцыг илүү сайн санхүүжүүлэх боломжтой гэж үзэж байлаа. Гэтэл үүний нөгөө талд аймгууд татварын хамгийн гол орлогуудаа төвлөрсөн төсөв рүү шилжүүлэх шаардлагатай болж, тэдгээрийн мөнгө санхүүгийн хөдөлгөөн ихээхэн хумигдахад хүрсэн юм. Аймгуудын хөгжлийн төлөвлөгөө нь төсвийн татаасаас үндсэндээ хамаарч эхлэв. Аймгуудын татвар бүрдүүлэх сонирхол буурлаа. Санхүү, эдийн засгийн шинэ бодлого Засгийн газраас баримталж буй бүсчилсэн хөгжлийн бодлоготой ийнхүү анхнаасаа зөрчилдөхөд хүргэв. Бүсчилсэн хөгжлийн бодлого нь хөдөөг бүсчлэн хөгжүүлэх хөгжлийн чиг баримтлалаар хязгаарлагдах биш, тэдгээрийн бие даасан хөгжил дээр тулгуурлах учиртай байв¹.

Санхүү, зээлийн бодлого нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалтай нэн их холбоотой учраас МАХН-ын Засгийн газар үүнд онцгой анхаарал хандуулж байв. Монгол улс 1991-2002 онуудад нийтдээ 2,4 тэрбум ам. долларын албан ёсны хөгжлийн тусламж (зээл, тусламж, төсөл, техникийн ба санхүүгийн хамтын ажиллагаа) авчээ. Үүний 54% нь буюу 1,3 тэрбум ам. доллар нь буцалтгүй тусламж байсан бол 46% нь буюу 1,1 тэрбум ам. доллар нь урт хугацааны хөнгөлөлттэй зээл байв. Монголд олгогдсон зээлийн 32%-ийг Азийн Хөгжлийн Банк, 21%-ийг Япон, 16%-ийг Дэлхийн Банк, 31%-ийг бусад хандивлагч улс болон олон улсын байгууллагууд эзэлж байна. 922 сая ам. долларыг (=84%) төслийн санхүүжилтэд, 122 сая ам. долларыг (=11,1%) санхүүгийн зээл болгон ашиглуулахаар олгожээ. Сангийн сайд Ч. Улааны мэдэгдсэнээр авсан зээлийн нийт хэмжээ (Орост төлөх "их өр"-ийг үл оролцуулан) ДНБ-ий 90% орчимтой тэнцэж буй аж. Зээлийн үзүүлэлт ДНБ-ий 60%-тай тэнцэхэд тухайн орон зээл олгогчдын бүрэн хамааралд ордог гэсэн жишгээс авч үзэх юм бол Монголын төрийн өр аюулын хэм хэмжээнээс дэндүү давсан байна². Тийм учраас Засгийн газар эдийн засаг, санхүүгийн бодлогодоо: 1. ДНБ-д эзлэх зээлийн хэмжээг бууруулах, 2. зээл тусламжийг зөвхөн зайлшгүй төслүүдэд оруулах, 3. зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, 4. хөгжлийн албан ёсны тусламжийн ашиглалтын удирдлага, зохицуулалтыг сайжруулах асуудлыг голлон анхаарах болов³.

Үүнтэй холбогдуулан Оросын Холбооны Улс (ОХУ)-д төлөх (Зөвлөлтийн үеийн) их өр 11,6 тэрбум ам. долларын 98%-ийг чөлөөлөх тухай баримт бичигт Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Л. Эрдэнэчулуун, ОХУ-ын Гадаад Хэргийн сайд С. Иванов нар 2004 оны 01 сарын 13-нд гарын үсэг зурсан явдал нь Монголын гадаад бодлогын чухал амжилтыг илэрхийлсэн билээ. Монгол улс "их өр"-ийн үлдсэн 2%-ийг (=250 сая ам. доллар) "маш богино хугацаанд" төлсөн нь сөрөг хүчнээс шүүмжлэл хүлээсэн ч Монгол Улсад олон улсын зээл хүртээх итгэлийг улам бэхжүүлж чадсан юм.

Засгийн газар хувьчлалын бодлогыг тууштай үргэлжлүүлэв. Банк, даатгалын газрууд, дулааны станци, цахилгаан түгээх сүлжээ, нүүрсний уурхай

44(281)2002, х. 1324-1327; 2002.06.27-ны өдөр батлагдсан Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, *Үнэн*, 2002.08.14.

¹ 2001.06.14-ны өдөр батлагдсан Бүсчилсэн хөгжлийн тухай УИХ-ын тогтоол, *Зууны Мэдээ*, 2001.07.25; Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, *Төрийн мэдээлэл*, 2003.06.30, х. 571-605; 2003 05.30-ны Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай Монгол Улсын хууль, *Төрийн мэдээлэл* 23(308)2003, х. 543-549.

² Д. Тунгалаг, Д. Цэрэнпил, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал, Улаанбаатар 2002, х. 133.

³ Хандивлагчид Засгийн газрын үйл ажиллагаа, хичээл зүтгэлийг үнэлж байна,

болон стратегийн ач холбогдол өндөртэй НИК шатахуун түгээх станцийг хувьчиллаа. 2000-2003 онуудын хооронд нийтдээ 78 улсын аж ахуйн нэгжүүдийг хувьчилжээ. Хувьчлалаас 48,3 тэрбум төгрөг улсын төсөвт орсон ба зөвхөн 2003 онд 19,4 тэрбум төгрөг оржээ (тэгвэл 1996-2000 онуудад 928 аж ахуйн нэгж хувьчлагдаж, 42,5 тэрбум төгрөг төсөвт орсон байна)¹.

УИХ 2002 онд газар хувьчлах тухай хуулийг баталсан нь хувьчлалын үйл явц болон зах зээлийн эдийн засгийн харилцаанд эргэлзээгүй чухал ач холбогдолтой байлаа. Хот суурингуудад газар хувьчлагдаж өмч болон хувирлаа. Энэ хуулийн онцлоуштай нь гэвэл өрх бүрт өргөдлийн дагуу 0,07 га хүртэл газрыг (=Улаанбаатар, аймгийн төвүүдэд 0,35 га хүртэл) үнэ төлбөргүй хувьчлахаар заасан явдал юм. Уг хуулийн эерэг үр дүнг Улаанбаатар хотын өнцөг булан бүрээс харж болно. Барилга, орон сууц барих ажил маш далайцтай явагдах боллоо. Газар өмч болж буй энэ үед түүнтэй холбоотой эрх зүйн болон бусад хүндрэл бэрхшээл гарах нь хэн бүхэнд ойлгомжтой хэрэг билээ.

Гадаад бодлогын амжилт ба учир холбоос

Ерөнхий сайд Н. Энхбаярын кабинет гадаад бодлогоо 1994 онд УИХ-аас баталсан "Гадаад бодлогын үзэл баримтлал"-ын зарчмууд дээр тулгуурлан хэрэгжүүлэв. Тэрээр үүнийг үндэс болгон дэлхийн хамгийн чухал улс орнууд болон олон улсын байгууллагуудтай харилцаа нилээн их өргөтгөж чадлаа. Гадаад бодлогын чиг баримтлалын цөм нь Монгол Улсын түүхэн туршлагаас улбаалан "гурав дахь түнш"-ийн тусламжтайгаар хөрш Орос, Хятад улстай тэнцвэртэйгээр харилцахад оршиж буй юм². Гадаад худалдаа, эдийн засгийн харилцаанд Хятад улсын өсөн нэмэгдэж буй давамгайллын улмаас Монголын Засгийн газар АНУ-ыг "гурав дахь түнш" хэмээн ямарваа эргэлзээгүйгээр үзэх болов. Дэлхийн Худалдааны Төвд халдсан алан хядах ажиллагааны (2001 оны 09 сарын 11) дараахан Ерөнхий сайд Н. Энхбаяр АНУ-д айлчлахдаа тус улсын АНУ-тай харилцах харилцааг "Монгол Улсын тусгаар тогтнол, батлан хамгаалал, хөгжил, ирээдүйд оруулж буй хувь нэмэр мөн" хэмээн тодорхойлсон байдаг³. Иракийн дайны үеэр АНУ-ыг дэмжигч орнуудын тоонд Монгол багтаж байсан ба 2003 оны 09 сард 180 цэрэг бүхий тусламжийн багийг Багдад руу илгээсэн юм.

Монголын гадаад бодлого АНУ-ын зүгт түлхүү чиглэх болсон нь хөрш Орос, Хятад улс түүнд хариу үйлдэл хийхээс аргагүйд хүргэсэн юм. Энэ хоёр орон (зөвхөн Монгол Улсын төсөв санхүүд чиглээд зогсохгүй) Монголын Засгийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар "дэгээдэж" авахаар шийджээ. Хятадын Ерөнхийлөгч Ху Жинтао 2003 оны зун Улаанбаатарт төрийн айлчлал хийхдээ 300 сая америк долларын зээл өгөхөө амласан бол Орос "их өр"-ийг тэглэсэн юм. Бээжин болоод Москва Улаанбаатараас хариу зүйл хийхийг хүлээж байлаа. Монгол улс Шанхайн Чуулганд нэгдэн орох алхам хийхийг тэд хүсч байв. 2004 оны 01 сарын 13-нд их өрийг тэглэх тухай баримт бичигт гарын үсэг зурснаас хэдэн цагийн дараа Орос, Монголын Гадаад хэргийн сайд нар Шанхайн Чуулганд оролцохоор Бээжин нислээ. Монгол улс энэ Чуулганд анх удаа ажиглагчаар оролцсон юм. Энэ хооронд өөрийн ашиг сонирхлоо Монголд тодотгон, Монголыг Шанхайн Чуулганд элсэх эсэхийг хардан ажиглаж байсан АНУ Монголын Засгийн газарт өөрийн үгээ хэлэх цаг нь болсон байлаа. 2004 оны 01 сарын 13-нд Гадаад хэргийн сайд Л. Эрдэнэчулуун, С. Иванов нарын гарын үсэг зурсан баримтын бэх хатаж амжаагүй байхад – АНУ-ын Зэвсэгт хүчний нэгдсэн штабын тэргүүлэгчдийн хорооны дарга генерал Ричард В.

¹ Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөрийг баталлаа, *Зууны Мэдээ*, 2004.01.14.

² У. Баркманн, Монголд гурав дахь түнш хэрэгтэй юу? Түүхэн сургамж ба эдүгээ үе, У. Баркманн, Л. Хайсандай, *Монгол-Германы харилцаа*, Улаанбаатар 2004, х. 214-219.

³ Монгол Улсыг АНУ-д аль аль хэдийн таньжээ, *Үнэн*, 2001.11.23.

Майерс Монголд 13.00-18.00 цагийн хооронд ирээд буцсан юм. АНУ-ын Зэвсэгт хүчний төлөвлөлтийн штабын дарга хурандаа генерал Хенри Нордын хамт хүрэлцэн ирсэн Майерс Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд Батлан хамгаалахын сайд болон Зэвсэгт хүчний жанжин штабын даргатай уулзаж ярилцсан юм. "Маш давчуу хугацаатай" ирсэн учраас ярилцлагад хэвлэл мэдээллийнхнийг байлцуулсангүй.

АНУ-ын Гадаад хэргийн орлогч сайд Ричард Л. Армитейж мөн оны 02 сарын эхээр Монголд богино хугацаанд айлчлав. Тэрээр АНУ-ын Ерөнхийлөгч Ж. Буш болон Гадаад хэргийн сайд К. Пауэл нарын хувийн даалгавраар Монголд ирсэн юм. Тэрээр нэгдүгээрт Афганистан, Иракийн сэргээн босголтод идэвхитэй оролцсонд Монголын Засгийн газарт талархсанаа илэрхийлэх, хоёрдугаарт Монгол-Америкийн харилцааны хэтийн хандлага сайн байгааг ойлгомжтой болгох үүрэгтэй байлаа. Ерөнхийлөгч Ж. Буш хоёр орны харилцааг хөрөнгө оруулалт, боловсролын салбарт өргөжүүлэн гүнзгийрүүлэх боломжийг Монголд судлаад ирэхийг Армитейжид захисан байлаа.

Армитейж Монголын Засгийн газарт өндөр амлалтууд өгчээ. Монгол улс тусламжийн шинэ хөтөлбөр болох "Мянганы сорилын сан"-д хамрагдах анхны орнуудын тоонд орох болов. АНУ Монголтой "Чөлөөт худалдааны гэрээ" байгуулах асуудлыг судалж үзнэ гэдгээ мөн Армитейж илэрхийлэв. АНУ-ын Ерөнхийлөгч Бушийн нэрийн өмнөөс тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Багабандийг ойрын хугацаанд албан ёсоор АНУ-д айлчлахыг урьсан юм. Армитейж Монгол Улсын Ерөнхийлөгч Багабандид бараалхсны дараагаар АНУ-ын ЭСЯ-ны байранд сөрөг хүчний намуудын төлөөлөгчид, Ардчилсан Намын дарга М. Энхсайхан, Ерөнхийлөгч асан П. Очирбат, Ерөнхий сайд асан Ц. Элбэгдорж, Р. Амаржаргал болон Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын тэргүүн С. Оюун нартай уулзав. Болох гэж буй сонгуультай холбогдуулан ямар хүндрэл бэрхшээл байгааг АНУ-ын Гадаад хэргийн орлогч сайд тэднээс асуув. Р. Амаржаргал, С. Оюун нар хөдөөгийн хүн амын мэдээллээ авдаг ганц эх сурвалж нь болох Үндэсний телевиз, радио МАХН-ын гарт бүрэн байдаг, тийм учраас сөрөг хүчин орон даяар цацагддаг тэрхүү мэдээллийн хэрэгслүүдээр орон нутгийн иргэдэд дуу хоолойгоо хүргэх боломжгүй байдгийг дурьдлаа. Ярилцлагад оролцогчид МАХН сонгуулийн хороодын бүхий л хариуцлагатай албан тушаалд өөрсдийн хүмүүсээ тавих аюул байгааг тэмдэглэн хэлэв. Сөрөг хүчний улс төрчдийн өгсөн тайлбарыг Армитейж сонсоод сонгууль шударга явагдах эсэхэд сэтгэл зовниж буйгаа илэрхийлсэн юм. Гадаад хэргийн орлогч сайд Армитейжийн МАХН-ын удирдлагатай хийх дараагийн уулзалт болоогүй бололтой. Энэ нь Америкийн зарим улс төрчдийн хувьд Монгол Улс Шанхайн бүлэгт нэгдэн орох эсэх тухай яриа хэлцэлд цэг тавьж болох нэгэн зүтгүүштэй хувилбар нь Ардчилсан Намын Засгийн газар бий болох явдал байсан байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Сөрөг хүчний өгсөн үнэлэлтээс улбаалан Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (БНОУХ) тэдний "Эх орон- Ардчилал" эвсэлд үзүүлэх дэмжлэгээ юутай ч нэмэгдүүлсэн. Энэ дэмжлэг ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга В. Б. Ружайко-ын Монголд айлчилсны дараа хүч нэмсэн юм. Монголын парламентын сонгууль ийнхүү гадаад бодлогын ашиг сонирхлын нэгэн зангилаа болж орхив.

МАХН ба сөрөг хүчний харьцаа

МАХН-ын удирдлага зүй нь УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажилд аажуу тайван орж болохоор байв. Засгийн газар нь нилээн сайн ажилласан байсан юм. Өнгөрсөн дөрвөн жилд улс оронд тодорхой хэмжээгээр тогтвортой байдлыг бий болгосон тул сонгогчид зохих хэмжээгээр урамшуулан саналаа өгөх байх гэж тус нам найдаж байлаа. Түүний сацуу МАХН 2003 онд Социалист Интернациональ-д элссэн явдал нь хүн амын дунд намыг шинэчлэх үйл явцыг

олон улсын хэмжээнд хүртэл үнэлж байна гэсэн дохио болж өгсөн юм. Өнгөрсөн жилүүдэд нам дотооддоо нилээн тогтворжиж чадав. Жилд дунджаар 5.000-6.000 (2003 онд бүр 11.400) хүн намд шинээр элсэв. 2004 оны 02 сар гэхэд намын гишүүдийн тоо ойролцоогоор 131.000-д хүрсэн байлаа¹. Намын дарга Н. Энхбаяр 2001 оны 10 сард Д. Идэвхтэнг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар (ЕНБД) томилсон нь азтай явдал байв. Ерөнхий нарийн бичгийн дарга Д. Идэвхтэн намыг удирдах тодорхой стратегич гэдгээ харуулах хэрэгтэй болов.

МАХН нь улс төрийн нам мөн гэдгээ байнга харуулж чадаж байсан бол сөрөг хүчин Монголын улс төрийн амьдралд 2002 оны төгсгөл хүртэл үндсэндээ мэдрэгдсэнгүй. Хэвлэл мэдээлийн хэрэгслээр АН-ын удирдлага зөрчил маргаантай байгаа тухай нийтлэл л гарч байв. Гэсэн хэдий ч сөрөг хүчин нэгэн чухал алхмыг хийж чадсан юм. Сөрөг хүчнийхний дотоодын хагарал бутрал сонгуульд ялагдахын нэг гол шалтгаан байсан гэдэг дээр сөрөг хүчний лидерүүд 2000 оны сонгуулийн сүйрлийн дараагаар санал нэгдэв. Тэд дүгнэлт хийж, сөрөг хүчний гол намууд нэг нам болон нэгдэх цаг нь ирсэн гэж үзлээ. 2000 оны 12 сарын 06-нд Монголын Үндэсний Ардчилсан Намын (МУАН) Монголын Социаль-Демократ Намын (МСДН) идэвхитэй оролцоотойгоор Монголын Ардчилсан Сэргэн Мандлын Нам (МАСМН), Монголын Шашинтны Ардчилсан Нам (МШАН) болон Монголын Уламжлалын Нэгдсэн Намын (МУНН) нэгээхэн хэсэг Ардчилсан Намыг байгуулан нэгдэв. Нэгдсэн шинэ нам байгуулагдах үедээ өөрсдийнх нь мэдэгдсэнээр 160.000 орчим гишүүнтэй болоод байжээ². АН-д нэгдэн орсон намууд хэдийгээр эвсэн нийлэх чадамжтай ч нэрнээсээ аваад улс төрийн өөр өөр үзэл бодлыг төлөөлж байв.

Улс төрийн хүчнүүдийг тооны хувьд цөөлөн нэгтгэснээр богино хугацаанд нөлөө бүхий нам байгуулж болно хэмээн тэд үзэж байлаа. Энэ үзэл зөвхөн тодорхой нөхцөлд л зөв байсныг харуулав. МАХН-ын эсрэг баруун талд зогсож буй сөрөг намуудын тоо ийнхүү нэгдсэнээр багасч чадсан юм. Харин энэ богино хугацаанд АН-ыг нэгэн цул буюу хомогон нам болгон хөгжүүлэх зорилт эхний удаад мөрөөдөл болон үлдэв. Намуудын нэгдэх үйл явцад анхнаасаа хүндрэл учруулж байсан зүйл нь үзэл сурталдаа маш нягтарч чадсан соцдекүүд АН-ын либерал байр суурийг илүү социаль-демократ үзэл рүү чирэх гэж оролдож байсан явдал байв. МАХН аль хэдийн социаль-демократ үзлийн байр суурийг аль хэдийн эзэлчихсэн байхад шүү дээ! Тэртээ тэргүй сул байгаа эдийн засгийг хөгжүүлэхэд ухаалаг либерал бодлогыг дэвшүүлэх шаардлага бол харин байнга л тавигдаж байсан.

Энд нэгэн зүйлийг анзааралгүй өнгөрч үл болно. Сүүлийн жилүүдэд гарсан эдийн засгийн дэвшил нь төрийн ухаалаг зохицуулалтын үр дүн биш, харин зах зээлийн харилцааны үйлчлэлийн үр дүн байсан юм. Улсын төсөвт сахилга батыг тогтоож, эдийн засгийг үндсэнд нь чөлөөтэй байлгасан МАХН-ын эдийн засаг, санхүүгийн бодлого уг амжитын нэгэн нууц байсан ч байж болох. Монголын компаниуд Засгийн газрын татварын бодлогыг олон улсын хэв шинжээр шүүмжилж байсныг айхтар ноцтойгоор хүлээн авах хэрэггүй юм. Учир нь тэдний дийлэнх нь өөрсдийн зүгээс эдийн засгийн хувьд байж болох нэг л татварын хэмжээг төлж байлаа. Хэрэв ирэх жилүүдэд илүү их татвар хураахаар тэмүүлвэл энэ нь Монголын төр өр нь улам нэмэгдээд байдаг өнөөгийн зээлийн бодлогын улмаас л болж хийх болов уу.

Энэхүү бодит байдлын үүднээс харвал, тухайлбал АН-ын дарга М. Энхсайхан болон АН-ын соцдекүүдийн хоорондох сөргөлдөөн, мөн түүнчлэн

¹ Б. Чинбилиг, МАХН бүл нэмлээ. Үнэн, 2004.02.03. МАХН-ын гишүүдийн тоо 2003 оны сүүлээр 131.473 хүрсэн гэдэг статистик бий. Түүний 35% нь 18-35 насны бүлэгт, 30% нь 36-45, 24% нь 46-60, 12% нь 61-ээс дээш насны бүлэгт тус тус багтаж байв. Гишүүдийн 25% дээд боловсролтой, 21 % нь тусгай болон бүрэн дунд боловсролтой. 26% хувийн секторт ажилладаг байна. Мэдээллийг: Жа Пүрэв, Элсэгчид нь залуужиж, эгнээгээ тэлж байна, Үнэн, 2004.03.01.

² Ардчилсан намын түүхэн товчоон, АН-ын удирдлагын баримт, Улаанбаатар 2004.

экс-соцдек Р. Гончигдоржийн тэргүүлдэг нөлөө бүхий “Алтан гадас” нийгэмлэгээс М. Энхсайханы эсрэг сонгуулийн өмнөх жил 2003 онд явуулсан дайралт нь нам доторх бодлогын өрсөлдөөн гэхээсээ илүүтэй эрх мэдлийн төлөө тэмцэл болон үйлчилж байв. Түүгээр үл барам тэр үеийн МСДН-ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Л. Бямбажаргал нарын экс-соцдекүүдийн нэгэн бүлэглэл байсаар байгаа бөгөөд, гаднаас нь ажиглавал, үзэл суртлынхаа чиг хандлагаас шалтгаалан хүсээгүй ч гэлээ МАХН-ын нууц морьдын нэг юмуу гэмээр сэтгэгдэл төрүүлж байсан юм. Энэ бүлэглэл сонгуулийн өмнөх жилд цөөнгүй удаа МСДН-ыг шинээр байгуулна хэмээн аашилсан юм. Хуучин МСДН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Л. Бямбажаргал дараах тайлбарыг өгч байв: “Өнөөдөр АН ‘хүчтэй нь амьдар’ гэсэн барууны үзэл баримтлал руу л яваад байна... Энэ үзэл бол социаль демократ үзэлд нийцэхгүй.”¹

Улс төрийн хувьд азгүй Д. Дорлигжав даргын үед нуугдмалаар үргэлжилж байсан намын дотоод тэмцэл маргааныг юутай ч зогсоох хэрэгтэй байлаа. 2003 оны 03 сард М. Энхсайханыг намын даргаар сонгосон явдал үүний баталгаа болов. М. Энхсайханд нэг талаас намыг чанга удирдаж, нэгтгэн барих эрх мэдлийн зөн, чадамж бий ч нөгөө талаас түүнд харизматик чанар байсангүй. Тэрээр өөрийн дагалдан яваа хүмүүстэйгээ эцгийн халамжаар дипломат харилцахын оронд хэтэрхий том эрх мэдэлтний байдлаар харьцаж байв. М. Энхсайхан намын дарга болохоос өмнө сонгогчдын дунд АН мартагдах аюул үүсэх нь гэсэн бодол АН-ын удирдлагад суусан байв. Олон нийт рүү хандсан тодорхой үйлдлүүдээр өөрсдийгөө болон намаа сонгогчдын ухамсарт дахин суулгахаар АН-ын зарим идэвхитнүүд ажиллаж эхлэв. АН-ын идэвхитэй гишүүн Э. Бат-Үүл 2002 оны өвөл Сүхбаатарын талбай дээр “Газрыг шудрагаар хувьчлахын төлөө - тракторчдын жагсаал”-ыг зохион байгуулав. Энэ жагсаал газрыг хувьчлах тухай хуулийг хэрэгжүүлэхийн эсрэг тэмцэл байв. Монгол оронд өвлийн улирал улс төрийн хувьд огт “үйл явдалгүй” цаг хугацаа байдаг учраас энэ ажиллагаа зөвхөн өдөр тутмын хэвлэлүүдээр бичигдэж байсан ба төрийн эрх мэдэлтнүүд цагдаагийн хүчээр тараан дуусгасан юм. Уг жагсаал олон нийтийн барагтай дэмжлэг аваагүй юм. Улаанбаатарын оршин суугчдын дийлэнх олонх нь газар хувьдаа өмчлөх боломж олгож буй уг хууль батлагдан гарсныг сайшааж байв.

МАХН-тай тэмцэх улс төрийн тэмцэлдээ АН 2003 оны эхээр “бохир PR” бүхий арга хэмжээг хэрэглэв. УИХ-ын гишүүн Л. Гүндалайд (АН) Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц. Нямдорж Хятадын нууц албаны тагнуул байсан тухай ТЕГ-ын гүйцэтгэх албаны баримт “цэвэр тохиолдлын байдлаар” ирэх нь тэр. Монголын уншигчдад сонин уншихад эвгүй ишлэлүүд тавигдаж, бүр эрүүгийн хариуцлагад хэн нэгийг татахад хүргэсэн хурцадмал байдал үүсэв. ТЕГ-ын нэгэн генерал энэ дуулиантай холбогдон хэдэн жилээр хоригдох ял хүлээсэн бол улс төрийн өрсөлдөгчид болох Л. Гүндалай, Ц. Нямдорж нарын хувьд тэдний хооронд юу ч болоогүй юм шиг улс төрийн ажлаа үргэлжлүүлэх цаг хэзээ нэгтээ ирсэн юм.

АН 2004 оны сонгууль руу анхаарлаа хандуулан сөрөг хүчний чухал намууд болох бизнесмен Б. Эрдэнэбатын хатуу босоо удирдлагатай Эх орон-Монголын Ардчилсан Шинэ Социалист Нам (Эх орон-МАШСН), харизматик хатагтай С. Оюуны (иргэний эрхийн төлөө тэмцэгч, бусдад алагдсан С. Зоригийн төрсөн дүү) тэргүүлдэг Иргэний Зориг Нам (ИЗН), этгээд авирладаг бизнесмен Б. Жаргалсайханы Монголын Бүгд Найрамдах Нам (МБНН)-ыг сүүлд яаж ийгээд хийгдсэн эвсэл рүү татах нь маш чухал байлаа. М. Энхсайхан, Б. Эрдэнэбат нар нөхцөл байдлыг хэдийгээр өөр өөрөөр дүгнэж, зарим талаар олж тогтооход амаргүй хувийн амбицуудтай байсан ч түргэн гэгч хэл амаа ололцов. Тэд 2003

¹ Л. Бямбажаргал, Би МСДН-ыг сэргээх ажилд идэвхитэй оролцож байна, Зууны Мээээ, 2003.10.30.

оны 05 сард "Эх орон-Ардчилал" эвслийг байгуулж, 2003 оны 06 сарын 16-нд холбогдох Эвслийн дүрэмтэй болсон юм¹. Эвсэл байгуулах тухай яриа хэлцлийн үеэр Эх орон-МАШСН дотоод хатуу зохион байгуулалттай, санхүүгийн сайн боломжтой байсан нь эвсэл байгуулах бэлтгэл ажилд оролцохдоо хамаагүй илүү байна уу гэмээр сэтгэгдэл төрүүлж байлаа. АН Эх орон-МАШСН-тай Сонгуулийн эвсэл байгуулсан нь анхнаасаа санхүүгийн ашигтай байдлыг бий болгосон юм.

Сайн эхэлсэн ажил тун удалгүй асуудалд орж эхлэв. Р. Гончигдорж зэрэг улс төрчид өөрсдийн бодлогын үүднээс ИЗБНН-ыг эвсэлд оролцуулах асуудлыг хөндөж тавилаа. Энэ нь МАХН-д таалагдав. Улс төрийн нөлөө багатай намыг ийнхүү эвслийн салшгүй түнш болгох гэсэн үзлийг зарим хэвлэлүүд хааяа ч болов сурталчлах болов. ИЗБНН-ын ээдрээтэй дотоод байдал нь Германы төрийн эрхэнд гараагүй байх үеийн Ногоон намыг санагдуулж байлаа. 90-ээд оны эхэн үеийн иргэний хөдөлгөөний болон тухайн үеийн МҮАН-аас нүүр буруулсан хүмүүсээс ИЗН-ын гишүүд бүрэлдсэн юм. 2002 оны 02 сарын 22-нд ИЗН Б. Жаргалсайханы МБНН-тай нэгдэж ИЗБНН-ыг байгуулсны дараа тус нам хэд хэдэн задралын шалгуурыг даван туулахад хүрсэн билээ. Үүний шалтгаан нь намын гол удирдагчид болох С. Оюун, Б. Жаргалсайхан нарын угаасаа хоорондоо таарч тохироход тун бэрх үзэл бодол, шаардлагаас үүдэлтэй байв. Нэгдээд буй ИЗБНН-ын дарга болсон С. Оюун АН-тай түншлэх санал дэвшүүлсний дараахан Б. Жаргалсайхан уг саналыг эрс эсэргүүцэв. Харин Эх орон-МАШСН-тай нэгдэж болох тухай санаанд тэрээр эерэг хандаж байлаа. Гэхдээ Б. Эрдэнэбатын хувьд энэ тохиолдолд С. Оюун нэгдсэн намын дарга болохыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн биш байсан юм. "Эх орон-Ардчилал" эвсэл байгуулагдсан нь ИЗБНН улс төрийн хэн ч биш болж мэдэх аюулд хүрээд байв.

Гэхдээ Р. Гончигдорж ба түүний "Алтан гадас" нийгэмлэгийн төлөвлөгөө гарч ирлээ. Тэд ИЗБНН-ыг "Эх орон-Ардчилал" эвсэлд багтаахыг шаардав. Улс төрийн дуусалд ойртоод байсан С. Оюун ийнхүү гэнэт хүчтэй яригдах болов. Оюун энэхүү тааламжтай цаг үеийг ашиглан эвсэлд тодорхой шаардлагуудыг тавьсан ба тэдгээрийн зарим нь эвслийг бүр бүтэшгүй байдал руу чирэхээр байлаа. Тэрээр ИЗБНН-ын квотын шаардлагыг хангасан "Гурвалсан эвсэл" байгуулахыг шаардав. Түүний энэ шаардлага эвсэлд гамшигтай үр дагавар тарив. Эвслийн дүрэм хүчингүй болж, энэ нь эвсэл тарсантай адил зүйл боллоо. Тодорхой үзэл бодол, стратегитэй Б. Эрдэнэбат өөрийнх нь Эх орон- МАШСН өр нь зөв түншүүдтэй хамтарч ажиллаж байна уу? үгүй юу? гэдэгтээ тулсан бодолд хүрэв. С. Оюуны тавьсан шаардлагад АН-ын дарга М. Энхсайхан маш хөшүүн хандаж байсан учраас "Алтан гадас" нийгэмлэгээс тусламж ирнэ гэдгийг мэдэж байсан тэрээр АН-ын даргыг гүтгэж эхлэв. 2003 оны 10 сарын сүүлээр Б. Жаргалсайхан идэвхижиж, МБНН-ыг сэргээн байгуулахаар 10 сарын 23-нд Дээд шүүхэд хандсан тухайгаа мэдэгдлээ. Үүнийгээ ч гүйцэлдүүлж, 2004 оны 04 сарын 05-нд намаа сэргээн байгуулав². АН, Эх орон-МАШСН, ИЗБНН цаг хугацааны давдалд улам автсаар байлаа. Намуудын удирдлага хүссэн хүсээгүй тал талаас ирж, эвслийг баталгаажуулах хэрэгтэй болов. Эвсэхгүйгээр сонгуульд ялахгүй гэдэг нь тэдэнд дэндүү ойлгомжтой байлаа. 2004 оны 02 сарын 03-нд АН, Эх орон-МАШСН, ИЗБНН 2004 оны УИХ-ын сонгуулийн эвслийг эцэслэн үзэглэв. Бүгд маш оройтож хийгдэв.

МАХН сөрөг хүчний зөрчлүүдийг маш анхааралтай ажиглаж байв. Сөрөг хүчний намуудын доторх "гал" дээр хааяа нэг багахан хэмжээний тос нэмээд байхад ноёрхлоо тогтоох хуучны ухаан "divide et impera" (хуваа, тэгээд ноёрх!) бодитой болно гэдгийг тэд таньж мэдсэн байлаа. Түүний хажуугаар тэд сонгуулиас өмнө амжиж иргэний эрхийн төлөө тэмцэгч агсан С. Зоригийн

¹ "Эх орон-Ардчилал" эвслийн дүрэм, Улаанбаатар, 2003

² "Буянгийн" Жагаа шүүхэд хандав, *Зууны Мэдээ*, 2003.10.31.

аллагыг илрүүлэх зорилгоор өөрөө өөртөө эрсдэлтэй алхам хийж, нэгэн Joker "тоглосон" нь Европ дахь хамгийн чухал бөгөөд – Монголчууд ойлгож чадаагүй л байгаа - өөрсдөд нь бол (Монгол) ашиг тусгүй түншүүдийн өнөөг хүртэл хадгалж ирсэн сайн харилцааг удаан хугацаанд үргэлжлэхээр муутгахад хүргэж орхисон юм. Энэ үйлдэл гадаад бодлогын хүрээнд хортой байсан төдийгүй, хуучин "социалист уламжлалд" улс төрийн зорилгоор буруугаар ашиглагдаж байсан, одоо Ерөнхий сайдын эрх мэдэлд ажилладаг нэгэн агентлагийг учир утгын хямралд хүргэсэн юм.

УИХ-ын 2004 оны сонгуульд МАХН-ын гарааны нөхцөл сайн байсан хэдий ч МАХН-ын удирдлага, ялангуяа намын дарга н. Энхбаярын дотнын хүрээг нэгэн түгшүүр нөмөрсөн юм. Нам дотор олон урсгалууд байдаг ба тэдгээрт тухайлбал "Ерөнхийлөгчийн фракци" болон "Шударга ёс" бүлэг багтдаг. Тэд МАХН-ын дарга Н. Энхбаярын нам удирдах арга барилыг сүүлийн үед олонтаа шүүмжилсэн юм. Дотнын хүрээнийхэн уг байдлын талаар ярилцаад Бага хурлын гишүүдийг Н. Энхбаярын бүлгийн шугам руу тэднийг чиглүүлэхээр тогтсон байлаа. Н. Энхбаяр намын удирдах албан тушаалтнуудтай ярилцаж, МАХН-ын Бага хурлын 5-р хуралдааныг 2003 оны 12 сарын 15-нд хийхээр төвлөв. Бага хурлын хэлэлцэх асуудлын хамгийн гол нь маргаан байхгүй МАХН-ын дарга Н. Энхбаярын "Социалист Интернационал ба МАХН" гэсэн илтгэл байлаа¹. Намын дарга улс орны шилжилтийн үйл явцад хүлээсэн МАХН-ын үүрэг ролийн талаар дэлгэрэнгүй илтгэж, түүнийг Социнтерн үнэлж МАХН-ыг 2003 оны 10 сарын 28-нд гишүүнээр элсүүлэн авсныг эцэст нь тэмдэглэв. Глобальчлал, хүний эрх, ардчилал болон МАХН-ын Засгийн газрын сүүлийн дөрвөн жилийн амжилтын талаарх сэдвүүдийг урт илтгэлдээ өөрийн байр сууринаас их болгоомжлон хөндөж ярьсан юм. Бага хурлын төлөөлөгчдийг гайхшруулсан нэг зүйл нь намын дарга намын эв нэгдлийн асуудлыг хөндсөн сэдэв байлаа. Хуралд оролцогчдыг ийнхүү гэнэтийн байдлаар шахаанд ороход хүргэсэнд хамаарах илтгэлийн хэсгийг бүхлээр нь энд гаргаж тавихгүй бол боломжгүй юм. Энэ асуудлаар илтгэлд: "Тэгээд ч ардчилсан социалист үзлийн тулгын гурван чулуу нь эв нэгдэл, шударга ёс, эрх чөлөө билээ. Тийм болохоор МАХН-ын нэр хүндийг унагах, хүч чадлыг нь сулруулахыг хүсдэг аливаа хүчин сонгууль ойртох тусам манай намын гишүүдийн дунд яс хаяж, тэдний тухай, юуны түрүүн намын удирдлагын тухай элдэв цуу яриа дэгдээж, гүжирдлэг гүтгэлэг тараахыг оролддог. Манай намын зарим гишүүн, МАХН-тай нэр, амьдрал нь холбогдож ойлгогддог хүн, албан тушаалтан иймэрхүү бохир зорилготой хүмүүс, улстөрийн хүчний явуулгад автах, сонор сэрэмжгүй байх явдал урьд өмнө нь гарч байсныг та бид санаж байгаа учир энэ явдал дахин давтагдахаас ухамсартайгаар болгоомжлох хэрэгтэй. Иймэрхүү арчаагүй үйл ажиллагаа, эрээ цээргүй гүтгэлгийг илчлэн няцааж ард иргэд, сонгогчиддоо үнэн бодит байдлыг тайлбарлан ойлгуулах ажлыг идэвхжүүлэх ёстой. 'Ард түмэн өөрөө ойлгоно' гэж өөрсдийгөө тайвшруулж, гүтгэлэг гүжирдлэгийг няцаахгүй, засаж залруулахгүй сууж болохгүй. Худал хуурмаг гүтгэлгийг зохиогчид манай намыг сонгогчидоос, намын гишүүдийг нэг нэгнээс нь хөндийрүүлэх зорилготой юм. Ийм нөхцөлд бид гишүүдийнхээ ухамсартай сахилга, хоорондын итгэлцэл, ажил хэрэгч, хариуцлагатай үйл ажиллагаагаар эв нэгдлээ баталгаажуулах хэрэгтэй. Намын эв нэгдэл ялалтын чухал нөхцөл байдаг. Ийм учраас намынхаа нэрийн өмнөөс улстөрийн үйл ажиллагаанд хамгийн идэвхтэй оролцож, хамгийн их үүргийг хүлээж байгаа намын бага хурлын гишүүд Та бид намын Бага хурлын энэ удаагийн хуралдааны үеэр мянга, мянган гишүүд, сонгогчдынхоо итгэлийг хүндэтгэж, эв нэгдлийг хичээн сахих "Батламж" үйлдэн намдаа өргөн барих нь зүйтэй. Та биднээс манай намын анхан ба дунд шатанд сонгогдсон журмын

¹ Социалист Интернационал ба Монгол Ардын Хувьсгалт Нам, Үнэн, 2003.12.16.

нөхөд маань үлгэр дууриалал авна гэдэгт итгэж байна. Эв нэгдлийн зарчим нь боловсон хүчний бодлогыг тодорхойлоход нэгэн чухал шалгуур байх болно.”¹

Сүүлд намаас хасах асуудал авч хэлэлцсэн ажиллагааны үеэр тэрээр дээрх үгээ дахин “баталгаажуулсан” билээ. Тэрээр: “2004 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуульд МАХН олонхи болохын төлөө намынхаа бодлогыг дэмжин хүч чадлаа дайчлан ажиллахаа батламжилж байна. Хэрвээ намаас нэр дэвшихгүй бол манай намаас нэр дэвшигчтэй зэрэгцэн бусад намын нэрийн өмнөөс, эсвэл бие даан нэр дэвшихгүй. Харин намаас нэр дэвшсэн хүнийг сонгуулахын төлөө ажиллана.”²

Намын удирдлага намын нэн чухал удирдах албан тушаалтнуудыг өөрсдөдөө үнэнч зүтгэхээр болгож чадсан юм. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийг сүүлд харахад тэдгээр нь МАХН-ын удирдах төв байгууллагын сонголтоор гарч ирсэн нь тодорхой болсон юм.

Сонгууль эхлэхээс өмнө МАХН-ын Засгийн газар хүн амын тодорхой бүлгийг өөртөө татах, төрийн албан хаагчдыг цалинг нь нэмэх байдлаар өөртөө хандуулах боломжоо ашиглав. 2004 оны 03 сарын сүүлээр тэтгэвэр нэмснийг дуулгалаа³. Дараа нь 04 сарын 13-нд Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанаас шүүх, прокурорын ажилтнуудын цалинг 25%, цаашлаад 05 сарын 19-нд дүүрэг, сумдын ИТХ-ын дарга, засаг дарга нар болон хороо, багийн засаг дарга нарын цалинг нэмснийг мэдэгдсэн юм⁴. Цалинг нэмэх тухай Засгийн газрын тогтоол уг нь аль 2004 оны 02 сарын 18-нд гарсан ийнхүү оройтож мэдэгдсэн явдлыг сонгуулийн тактикийн алхам байжээ гэж үзэхээс аргагүйд хүргэж байгаа юм. 2004 оны 04 сарын 25-нд Засгийн газар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 34 ам. доллар болгон тогтоосныг хэвлэлээр дамжуулан мэдэгдэв⁵.

Ерөнхий сайд Н. Энхбаяр, Ерөнхийлөгч Н. Багабанди нарын зөрчил

Монгол Улсад улс төрийн өөрчлөлт хийгдэж эхэлснээс хойш Төрийн тэргүүнээр хоёр хүн сонгогдоод байна. П. Очирбат, Н. Багабанди нар хоёул их бага хэмжээгээр МАХН-аас нэр дэвшин хоёул тус бүр нэг удаа улиран сонгогдсон билээ. Монгол Улсын Ерөнхийлөгч нь 1991 оны 08 сарын 28-ны өдрийн “Намын гишүүнээс түдгэлзэх албан тушаалын тухай хууль”-ийн дагуу албан тушаалаа хашиж дуустал намын гишүүнчлэлээсээ түдгэлзэх үүрэг хүлээдэг юм. Үндсэн хуульд “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.”⁶ гэж заасан байдаг. Энэ заалт бол маш тодорхой бөгөөд ойлгомжтой заалт. Ерөнхийлөгч улс төрийн хувьд төвийг сахиж, аль нэг намын улс төрийн ашиг сонирхолд хөтлөгдөж болохгүй. Үндсэн хуулийн энэ үзэл санааг хэрэгжүүлэхэд МАХН-ын удирдлага П. Очирбат болоод Н. Багабандитай бэрхшээлтэй тулгарч байв. МАХН-ын лидер улс төрчид намын дотоод сахилга батын асуудалд онцгой ач холбогдол өгдөг нь хэвээр байгаа. Энэ нь зарчмын хувьд буруу биш ба аливаа улс төрийн намын үйл ажиллагаагаа явуулах нэн чухал баталгаа нь байдаг билээ. Харин буруу нь гэвэл, Ерөнхийлөгч Үндсэн хуулиар хориглосны дагуу намын бодлогын тулгалтын гадна байх учиртай тул дээрх хэмжүүрийг Ерөнхийлөгчид тавьж болохгүй юм. П. Очирбат, Н.Багабанди нарын хэн нь ч тийм тулгалтын өмнө бөхийж байгаагүй нь бодит үнэн билээ. Хэрэв тэгсэн бол тэд энэ өндөр албан тушаалд ихээхэн хохирол учруулах байлаа.

¹ Социалист Интернационал ба Монгол Ардын Хувьсгалт Нам, *Үнэн*, 2003.12.16.

² Д. Оюунхоролыг МАХН-аас хаслаа, *Үнэн*, 2003.05.22.

³ *Зууны Мэдээ*, 2004.03.25.

⁴ *Зууны Мэдээ*, 2004.05.19.

⁵ *Зууны Мэдээ*, 2004.04.15.

⁶ Монгол Улсын үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд (1924-1992), Улаанбаатар, 1998, х. 96

Ерөнхий сайд Н. Энхбаяр, Ерөнхийлөгч Н. Багабанди нарын "найрлага" наандаж 1997 оноос бишдсэн явдал МАХН дотор нууц биш байсан юм. 1997 оны 02 сард Н. Энхбаяр биш, харин Н. Багабанди МАХН-ын дарга болсныг Н. Энхбаяр гэтлэн давж чадаагүй хэмээн зарим нь ярьдаг. Гэхдээ энэ байдал богино хугацаанд өөрчлөгдөв. МАХН-ын Бага хурлын 2-р хуралдаанаар 1997 онд Н. Багабанди 71,93 %-ийн саналаар Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээр тодорлоо. Мөн онд болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар Н. Багабанди сонгогчдын 60,8% санал авч ялалт байгуулсан юм. МАХН-ын Бага хурлын 3-р хуралдаанаар Н. Энхбаяр 98%-ийн саналаар намын даргаар сонгогдов. 1997 оны 08 сарын 17-нд хоёр Ерөнхийлөгч П. Очирбат, Н. Багабанди нарын төрсөн нутаг Завхан аймгийн 21-р тойрогт явагдсан нөхөн сонгуулиар Н. Энхбаяр саналын 72,6%-ийг авч УИХ-ын гишүүнээр сонгогдон сөрөг хүчин МАХН-ын бүлгийн дарга болсон юм.

Энэ цаг үеэс тэрээр УИХ-ын гишүүн засгийн газрын гишүүн байж болох асуудлыг Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхээр парламентад зүтгүүлж эхлэв. Ялсан намын дарга нь Ерөнхий сайд байх ёстой гэж тэрээр мөн үзэж байлаа. Түүний энэхүү зүтгүүлэг эрх мэдлийг төвлөрүүлэхэд чиглэж байсан нь тодорхой юм. Ерөнхийлөгч Н. Багабанди Үндсэн хуулийн ийм өөрчлөлтөөс татгалзсан нь МАХН-ын зарим удирдагчдын хүсэлд нийцсэнгүй. 2000 онд МАХН сонгуульд ялалт байгуулсны дараа ч МАХН-ын уг зүтгүүлэгт Н. Багабанди дахин няцаасан хариулт өгсөн нь УИХ дахь МАХН-ын бүлэг Ерөнхийлөгчийн байрь суурьтай анх удаа "шүүмжлэлтэй" үзэлцэхэд хүргэв. Ерөнхий сайд, Ерөнхийлөгч нарын хооронд ямаршуу зөрчилдөөнтэй харилцаа үүсээд байсан нь 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар улам тодров. МАХН хэдийгээр Н. Багабандийг нэр дэвшүүлсэн боловч МАХН-д ойр хэвлэлүүд Н. Багабандийг дэмжсэн нийтлэлээр ядмаг байлаа. Гэсэн ч Н. Багабанди сонгуулиар 58,1%-ийн санал авч ялалт байгуулсан нь юуны өмнө өөрийнх нь өсөн нэмэгдсэн улс төрийн нэр төртэй шууд хамааралтай байсан юм. Н. Багабанди МАХН-ын удирдах хүмүүсийн дунд өндөр үнэлэгдэж, дэмжлэг авч байсан нь хэнд ч ойлгогдох зүйл. МАХН-ын дотор "Ерөнхийлөгчийн фракци" нэртэй нэгэн бүлэглэл бий болов. Н. Энхбаярыг тойрсон бүлэглэл тэдгээр хүмүүстэй үл итгэл, хардах байдлаар харьцаж байв. Энэхүү үл итгэлцэл 2003 оны 11 сард "Ерөнхийлөгчийн засаглалын төлөө хөдөлгөөн" байгуулахад улам лавшрав. Энэ хөдөлгөөнд МАХН-ын болоод АН, ИЗБНН-ын гишүүд бас орсон байв. Хот хөдөөгийн 1.500 игэдийн дунд явуулсан санал асуулгаар хөдөөгийн иргэдийн 52%, хотынхны 40% нь Ерөнхийлөгчийн засаглалыг тогтоохын төлөө байгаагаа илэрхийлжээ. Улс төрийн намуудын дорой үйл ажиллагаа нь судалгаанд оролцогчдоос олон хүн хүчтэй төрийг хүсэмжлэхэд хүрээд байгааг юм.

Ерөнхий сайд, Ерөнхийлөгч нарын зөрчлийг улам хурцатгасан нэгэн үйл явдал дараа нь боллоо. Монголын ард түмэнд шинэ оны мэндчилгээ дэвшүүлэхдээ Ерөнхийлөгч Н. Багабанди: "Монгол Улсын Их Хурал болон орон нутгийн сонгууль болох учраас Монголын ард түмний хувьд 2004 он нэн хариуцлагатай, шинэ сонголтын жил байх болно" гэж хэлэв. Сөрөг хүчин энэ үгийг тэр дор нь өлгөн авч Ерөнхийлөгч сөрөг хүчний төлөө саналаа өгөхийг уриаллаа хэмээн тайлбарласан юм. МАХН-ын Удирдах зөвлөл мөн уг өгүүлбэр "МАХН-ын эсрэг сонгуулийн сурталчилгаа" байсан гэсэн тайлбар хийлээ¹. МАХН-ын төв удирдлага энэ асуудалд ямар их тэвдэж, зарим нь олон нийтийн өмнө хэрхэн баримжаагаа алдсаныг тэдний адайр хариу үйлдэл харуулсан юм. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Б. Батхишиг шинэ жилээр мэндчилж хэлсэн үгнийхээ зарим хэсэгт Ерөнхийлөгч тэр даруй байрь сууриа илэрхийлэх хүсэлтийг МАХН-ын Удирдах зөвлөл тавиагүйд нь харамсаж буйгаа мэдэгдээд

¹ Г. Гарав, Ерөнхийлөгчийн байрь суурь гайхал төрүүлэх боллоо, *Үнэн*, 2004.01.14.

дараах тайлбарыг өгөв: “Шинэ сонголт гэдгийг шинэ хөтөлбөрүүд гарч шинэ сонгуулийн кампани өрнөж, шинээр санал хураалт болж, шинээр сонгогдсон гишүүд шинэ мандатаа авна гэсэн утгаар л хэлсэн. Энэ нь одоогийн гишүүдээ битгий сонго гэсэн утга санаа байхгүй... Харин чухам аль намын хэнийг сонгохоо ард түмэн шийддэг.”¹ Хэд хоногийн дараагаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга АН-ын дарга М. Энхсайханд хандаж Ерөнхийлөгч Төрийн тэргүүнийхээ хувьд Монголын ард түмэнд дэвшүүлсэн мэндчилгээндээ хэлсэн “шинэ сонголт” гэдэг “хэлсэн үгийг утгыг гуйвуулж тайлбарлах, улс төрийн зорилгоор ашиглахыг зөвшөөрөхгүй”² байгааг мэдэгдсэн юм. Энэ будилал үнэн хэрэгтээ шоглоом болж, сонгуулийн өмнөхөн МАХН тэр үгэнд хэтэрхий их ач холбогдол өгснөөсөө болоод өөртөө илүү лай учруулсан юм. МАХН Ерөнхийлөгчтэй арай дэндүү харьцаж байна хэмээн олон монголчууд үзэж байсан юм. Ингэх нь ч ойлгомжгүй зүйл биш байлаа. Учир нь Н. Багабандийн нэр төр өндөр хэвээр байсан ба сүүлд явуулсан санал асуулгаар тус улсын шилдэг улс төрчдийн жагсаалтын хамгийн эхэнд түүний нэр байрласан байв.

Сонгогчдын санаа бодлын дүр төрх

УИХ-ын сонгуулийн талаар МАХН-нд ойрхон судалгааны “Прогноз” төв болон АН-д ойр Сант Маралын сангийн сонгогчдоос авсан санал асуулгын дүн ойролцоо гарсан юм. “Прогноз” төв 2004 оны 03 сарын 15-25-ны хооронд улсын хэмжээнд 8.460 иргэдээс танадалт авсан бол Сант Марал сан 2 удаа судалгаа (2004 оны 03.04-12, 2004 оны 05.30 – 06. 07) явуулав. Сант Марал сан эхний судалгаагаа Улаанбаатар, Увс, Булган, Дундговь, Баянхонгор, Дорнод аймгийн 1.663 иргэдээс хоёр дахь судалгаагаа Улаанбаатар, Налайх, Багануур, Ховд, Хөвсгөл, Төв болон Өмнөговь аймгийн 2.170 иргэдээс авчээ³. Судалгааны хоёр байгууллагын 2004 оны 03 сард явуулсан ижил төстэй асуулт бүхий санал асуулгын дүнг харьцуулах боломж бүрдсэнийг ашиглан харуулъя. Монгол Улсын өнөөгийн ерөнхий байдлыг судалгаанд хамрагдагсад хэрхэн дүгнэж байна вэ?

Монголын өнөөгийн байдал

Асуулт	Прогноз			Сант Марал сан (2004 оны 03 сар)		
	УБ	Хөдөө	Нийт дүн	УБ	Хөдөө	Нийт дүн
маш сайн	5,0	7,1	6,9	1	3	3
сайн	23,0	27,8	27,4	13	20	17
зарим талаар сайн, зарим талаар муу	33,0	34,9	34,7	49	50	50
тааруу	29,2	18,4	19,3	31	23	26
муу	5,9	5,6	5,6	5	4	4

Судалгаанд оролцогчдыг талаас илүү хувь нь Монголын өнөөгийн байдлыг тааруу гэж дүгнэсэн ба сонирхолтой нь хөдөөгийн иргэд байдалд арай эерэг үнэлгээ өгсөн байх юм. Нийгмийн ямар асуудал таныг онцгой эмзэглүүлж байна вэ? гэсэн “Прогноз” төвийн асуултад: 1. ажлын байрны асуудал (36,9%) 2. ядуурал ба бага орлого (36,6%), 3. архидалт (17,4%), 4. нийгэм ахуйн асуудал (10%), 5. хүүхэд, залуучуудын ирээдүй (9,2%), 6. үнийн өсөлт (8,2%), 7. авилгал ба худал амлал (7,6%) гэсэн хариултауд оржээ.

Энэ үнэлгээ тэгвэл Засгийн газрын үйл ажиллагаанд ямар үнэлэлт өгч байна вэ? гэсэн уялдаа асуултыг тавина. Гайхшралтай дүн гарсан. Ихэнх нь (Сант Марал сан: маш сайн+хангалттай= 62%, Прогноз: 56,6%) Засгийн газрын үйл ажиллагаанд илүү эерэг үнэлэлт өгчээ. “Прогноз” төвийн дүнгээр энэ

¹ Б. Батхшиг, Ерөнхийлөгчөөс өөрөөс нь асуучихаагүйг харамсаж байна, *Зууны Мэдээ*, 2004.01.14.

² Эвслийнхэн Ерөнхийлөгчийн хэлсэн үгийг уриа дуудлагаа болгон ашиглаж эхэллээ, *Үнэн*, 2004.01.27.

³ Sant Maral Foundation, Politbarometer, 21 March 2004, 22, Juni 2004; “Прогноз” төв 2004 оны гуравдугаар сарын 15-25-нд улс даяар 8460 хүн хамруулсан судалгаа хийжээ. Уг судалгааны дүнгээс нийтлэв, *Зууны Мэдээ*, 2004.04.14.

тохиолдолд хөдөө орон нутагт мөн л илүү сайн дүн (маш сайн+хангалттай =хот: 46,0%, хөдөө: 57,5%) тавигджээ.

Хэрэв маргааш сонгууль болбол аль намд та саналаа өгөх вэ гэсэн асуулт дараах дүнтэй гарав:

Хэрэв маргааш сонгууль болбол та аль намд саналаа өгөх вэ?

Асуулт	Прогноз			Сант Марал сан (2004 онб 03 сар)		
	УБ	Хөдөө	Нийт	УБ	Хөдөө	Нийт
МАХН	52,4	53,5	53,4	47	50	49
Эх орон-Ардчилал	25,9	28,9	28,6	25	31	29
АН						
МАШСН						
ИЗБНН						
МБНН	2,4	1,9	1,9			

Тайлбар: Эх орон-Ардчилал эвсэлд АН, Эх орон-МАШСН, ИЗБНН орсон болно. МБНН=Монголын Бүгд Найрамдах Нам

АН-д ойр Сант Марал сангийн судалгаагаар санал асуулгад оролцогчид сөрөг хүчний үйл ажиллагаанд тааруу санал өгсөн дүн гарсан байлаа.

Сөрөг хүчний үйл ажиллагааг та хэрхэн дүгнэж байна вэ?

Үнэлгээ	2004 оны 03 сар улсын хэмжээнд (хувиар)	2004 оны 06 сар улсын хэмжээнд (хувиар)
маш сайн	7	8
таалагддаг	29	29
бараг таалагддаггүй	42	42
огт таалагддаггүй	15	14

Сонгуулийн үеэр МАХН, түүний Засгийн газарт сонгогчдын ихэнх нь саналаа өгөх нь гэсэн гаргалгааг хоёр байгууллагын судалгаа харуулж байв. "Прогноз" төвийн 05 сарын сүүл, 06 сарын эхээр (05.20-27/13.800 оролцогч, 06.05-10/20.000 оролцогч) явуулсан болон "Универсал" багийн (05.28-06.15/7.000 оролцогч) судалгааны дүн дээрх хандлагыг мөн баталж өглөө. "Прогноз" төвийн судалгаанд хамрагдагсдын 48,5% нь МАХН-ын төлөө, ердөө 32,1% нь Эх орон-Ардчилал эвслийн төлөө саналаа өгөхөд бэлэн гэсэн дүн гарсан байлаа. "Универсал" багийн дүнгээр 50,82% нь МАХН-д, 36,45% нь Эх орон-Ардчилал эвсэлд өгнө гэсэн нь эвсэлд арай ахиу санал гарсан нь харагдаж байна. Шийдэж амжаагүй сонгогчдын хэмжээ "Прогноз" төвийн судалгаагаар 15%-тай гарсан нв харьцангуй өндөр үзүүлэлт байлаа¹.

Улс төрчдийн хувийн рейтинг

Сонгуулийн өмнөхөн МАХН, Эх орон-Ардчилал эвсэл хоёул өөрсдийн лидер улс төрчдийнхөө чансааг өсгөхийн тулд орчин үеийн PR суртчилгааг авч хэрэгжүүлэв. Ерөнхий сайд Н. Энхбаяр, МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д. Идэвхтэн нар энэ зорилгоор "Face PR" агентлаг, мэдээллийн "Дөрөв дэх засаглал" төвийг байгуулах санаачлага гаргажээ. Эдгээр байгууллага 02 сард Засгийн газарт талтай "Зууны мэдээ" сонинд "Ард түмэнд итгэл төрүүлсэн шилдэгийн шилдэг 99 улс төрчид" гэсэн тайлбаргүй шахам фото зургийг нийтлэв. Фото зургийн энэхүү эвлүүлэг МАХН-ын идэвхтнүүдийг ашигтайгаар толилон харуулах зорилго агуулав уу гэмээр байлаа. Ерөнхий сайд Н. Энхбаяр, Ерөнхийлөгч Н. Багабанди болон УИХ-ын дарга С. Төмөр-Очир нарын зургийг зориуд томруулан эхний эгнээнд байрлуулсан бол олны танил бусад хүмүүсийн зургийг жижиг хэмжээтэйгээр цагаан толгойн үсгийн дарааллаар байршуулсан

¹ Б. Түвшин, МАХН рейтингээрээ тэргүүлж байна, Зууны Мэдээ, 2004.06.19.

байв. Монголын уншигчдыг багагүй хувь нь цагаан толгойн үсгийн дарааллаа санахтайгаа байхад ийнхүү байршуулсан нь сөрөг хүчний төлөөлөгчид болох М. Энхсайхан, Ц. Элбэгдорж нарын нэрсийг уг дарааллаар хамгийн сүүлийн эгнээнд аваачихад үнэлгээний гол мэх нь байжээ. Тэгвэл сөрөг хүчин өөрийн сонин "Өдрийн сонин" болон Шуудан банк, "Сэрүүлэг" сонины дэмжлэгээр ижил цаг хугацаанд "Монголын шилдэг 76 улс төрч"-ийг шалгаруулсан нь дээрхтэй адил загвартай байсан ба ингэхдээ сөрөг хүчний улс төрчдийг түлхүү харж үзсэн байлаа. Эхний эгнээ нь мөн л үндсэн загвараас хазайсан байв. Ерөнхийлөгч Н. Багабандийн зурагтай зэрэгцүүлэн эвслийн удирдах улс төрчид Р. Гончигдорж, Л. Гүндалай, С. Оюун, Ц. Элбэгдорж, М. Энхсайхан болон Б. Эрдэнэбатын зургийг тавьжээ. Энэ эгнээнд гэхдээ улс төрчдийн хоёр хосыг (Л. Гүндалай+Ц. Нямдорж, Ерөнхий сайд Н. Энхбаяр+АН-ын дарга М. Энхсайхан) дараалан байршуулсан нь содон байлаа. "Өдрийн сонин"-д хэд хоногийн дараа "Хонин жилийн шилдэг 108 улс төрчийг Монголын Мэдээллийн Товчоо нэрлэж байна" нэртэй фото жагсаалтыг мөн нийтэлсэн юм.

МАХН-аас санаачилсан нь мэдэгдэж байсан энэ жагсаалт арай тэнцвэртэй харагдаж байлаа. Сонгуульд МАХН ямар нэр дэвшигчидтэй оролцох вэ гэдэгт хариу өгөх төлөөлөгчдийг энд харуулахыг зорьжээ. Юутай ч МАХН-аас сүүлд нэр дэвшсэн хүмүүсийн 46 нь энэ жагсаалтад орсон байсан юм. Энэ жагсаалтад харин анх удаа цөөнгүй бизнесменүүдийн зураг тавигдсан байсан юм. Эдгээр эдийн засгийн хүрээнийхэн өөрсдийн нөлөө ихтэйгээсээ болж тавигдав уу, эсвэл улс төрийн намуудыг санхүүгээр тэтгэдэг учраас оров уу гэдэг нь таагдашгүй үлдэв. Хэвлэлүүдээр нийтлэгдсэн PR-жагсаалт юутай ч чанарын шинэ зүйл байлаа. PR-санал асуулга хэтдээ Монголын улс төрийн амьдралд өсөн нэмэгдэх ач холбогдолтой байхаар байна. "Зууны Мэдээ" сонинд 03 сарын эхээр "Монгол Улсын түүхэнд онцгой гавьяа байгуулсан нийгэм-улс төрийн байгууллагыг нэрт 150 бие хүмүүс нэрлэж байна" гэсэн нэртэйгээр гарсан нийтлэл харин маш олхиогүй байв. Энд дурьдсанаар бол тэдний 127 нь МАХН-ыг нэрлэсэн гэх ажээ. Үнэн хэрэгтээ тэдний заримаас нь огтхон ч асуугаагүй байсныг тэд сүүлд нь хэлж байсан юм.

Монголын улс төрийн намуудын дүр төрх

Монгол улс төрийн намуудын дүр төрх – МАХН-ын эс тооцвол – улс төрийн өөрчлөлтийн дараа бүрэлдэн тогтсон юм. Улс төрийн намыг үүсгэн байгуулах, улс төрийн үйл ажиллагаа явуулах үндэс нь одоо зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаа 1990 оны 05 сарын 10-нд батлагдсан "Улс төрийн намуудын тухай хууль" юм. Энэ хуульд зааснаар шинэ нам байгуулахад 801 гишүүний гарын үсэг цуглуулахад хангалттай гэдгийг иш үндэс болгон өнгөрсөн хугацаанд олон шинэ намууд үүссэн билээ. Эдгээр намуудын дийлэнх нь тодорхой хувь хүмүүсийн хувийн амбицэд тулгуурласан байх ба улс төрийн өдөр тутмын амьдралд бараг нөлөөгүй байдаг. Тэд үнэн хэрэгтээ жинхэнэ гишүүдийн цөмгүй бөгөөд гишүүнчлэлийн тоог харахад ихэвчлэн Дээд шүүхэд бүртгүүлэх үедээ өгсөн тоо л тухайн намын гишүүнчлэлийн статистик болдог. Энэ баримт намын гишүүний тоо бодит биш байдгийг хэлээд байгаа юм. 2004 оны 04 сарын эхэн гэхэд Монголд улс төрийн 20 нам бүртгэгдсэн байна (хүснэгтийг үзнэ үү).

УИХ 2003 оны 05 сарын 23-нд "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай Монгол Улсын хууль"-ийг баталсан билээ. 2003 оны 10 сарын 01-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ч гайхалтай нь бүр 2004 оны 01 сарын 22-нд нийтлэгдсэн уг хууль нь¹ улс төрийн намууд (2003 оны 10 сарын 01-ээс эхлэн) 6 сарын дотор шинэчлэн бүртгүүлсэн байх ёстойг заажээ. Энэ заалтыг 2004 оны

¹ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Зууны Мэдээ, 2004.01.22.

04 сарын 05 хүртэл ердөө 10 нам л биелүүсэн байсан ба улс төрийн намуудын тоо хэмжээ барагтал хувиар багассан байна. Дараахь хүснэгтэд шинэчлэн бүртгэгдсэн намуудыг *italic*-ээр тэмдэглэсэн болно.

Бүртгүүлсэн улс төрийн намууд		
№	Улс төрийн намын нэр	Бүртгүүлсэн огноо
1	<i>Монгол Ардын Хувьсгалт Нам</i>	1990.05.16
2	<i>Ардчилсан Нам</i>	2000.12.26
3	<i>Монголын Ногоон Нам</i>	1990.05.26
4	<i>Монгол Ардын Нам</i>	1992.04.03
5	<i>Иргэний Зориг-Бүгд Найрамдах Нам</i>	2000.03.22
6	Монголын Ажилчны Нам	1992.06.03
7	<i>Монголын Уламжлалын Нэгдсэн Нам</i>	1994.01.14
8	<i>Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам</i>	1995.08.19
9	Монголын Уламжлалын Шударга Ёсны Нам	1995.04.20
10	Монголын Ардчилсан Социалист Нам	1998.04.17
11	Монголын Залуучуудын Нам	1998.05.11
12	<i>Монголын Либерал Ардчилсан Нам</i>	1998.05.21
13	<i>Эх орон-Монголын Ардчилсан Шинэ Социалист Нам</i>	1998.12.12
14	Монголын Коммунист Нам	1999.01.27
15	Монголын Хөдөөгийн Хөгжлийн Нам	1999.05.28
16	<i>Монголын Иргэний Ардчилсан Шинэ Либерал Нам</i>	2000.01.28
17	Монголын Шинэ Социаль Демократ Нам	2000.03.23
18	Монголын Угсаатны Нэгдсэн Социалист Нам	2000.12.29
19	Монголын Бүгд Найрамдах Нам	2004.04.05
20	Монголын Эмэгтэйчүүдийн Нэгдсэн Нам	2004.04.12

*Монголын Иргэний Ардчилсан Шинэ Либерал Нам 2004.04.05-нд Дээд шүүхэд намаа Монголын Либерал Нам болгон өөрчлөн нэрлэснээ мэдэгдсэн юм.

Заасан хугацаанд шинэчлэн бүртгүүлээгүй улс төрийн намуудыг шүүхийн шийдвэрээр тараасанд тооцохоор уг хуульд заасан байна¹. "УИХ-ын сонгуулийн тухай хууль"-д "...улсын бүртгэлд бүртгүүлсэн нам буюу намуудын эвсэл Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй."² гэж заасан тул зөвхөн шинэчлэн бүртгэгдсэн намууд сонгуульд оролцохоор болсон юм. Намуудын тоо хэмжээ багассан нь сөрөг хүчний намуудад ашигтай боллоо. Ингэснээр сонгуулийн өмнө сөрөг хүчний намууд бутран задрах аюул бага хэмжээнд ч болов буурсан юм. Одоо сөрөг хүчний лагерь боломжийн эвсэл байгуулаад авах асуудал л үлдлээ.

УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажил

Сонгуулийн хуулийн тухай хэлэлцүүлэг. 2004 оны эхээр улс төрийн намууд хүчин төгөлдөр "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль"-д өөрчлөлт оруулах талаар хэлэлцүүлэг өрнөв. Хэлэлцүүлгийн гол нь одоогийн хуулийн үзэл санаа улс төрийн тухайн намуудад хэрхэн ашигтай үйлчилдэг тухай асуудал дээр тогтож явагдав. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга сонгуулийн тойргийг томсгож, олон мандаттай болгох саналыг дэвшүүлж байв. Энэ саналаар бол одоогийн 76 тойргийн оронд 25 юм уу 26 тойрог байгуулагдана гэсэн үг байлаа (1992 онд 26 тойргоос 76 мандат сонгогдож байв). ИЗБНН-ын тэргүүн С. Оюун Улаанбаатар дахь тойргийн тоог нэмэн, сонгогчдын 25% саналаар сонгогддогийг болиулж, 50+1 хувиар сонгуульд ялсанд тооцдог байх зарчмыг оруулах, мөн гадаадад амьдардаг монголчуудыг сонгуульд оролцуулах санал дэвшүүлсэн юм³. Сонгуулийн хуульд өөрчлөлт

¹ "28.4: Энэ хуулийн 28.3-т заасан баримт бичгийг тогтосон хугацаанд бүртгэх байгууллагад ирүүлээгүй бол тухайн хуулийн этгээдийг бүртгэх байгууллагын саналыг үндэслэн шүүх татан буулгана", "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"-аас, Зууны Мэдээ, 2004.01.22.

² Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, Улаанбаатар, 1992, х. 3

³ ИЗБНН-ын сонгуулийн хуулийн төсөлд саналаа нэмэрлэв, Зууны Мэдээ, 2004.01.03. Сонгуулийн хуульд

оруулах асуудал Үндсэн хуулийн зарим зүйл заалтыг хөндөхөд хүргэж байгаа, мөн Ерөнхийлөгч Н. Багабанди Үндсэн хуульд өөрчлөлт хийхийг тодорхой шалтгаанаар нөөцөлж буй шалтгааны улмаас улс төрийн өрсөлдөгчид хэлэлцүүлгийг сонгуулийн өмнөхөн үргэлжлүүлэхээс татгалзсан юм.

Хэвлэл мэдээлэл дэх сонгуулийн сурвалжлага, нийтлэл. 2004 оны 04 сарын 14-ний өдөр тус улсын шилдэг сэтгүүлчид АНУ-ын Соросын сангийн санаачлагаар уулзаж, сэтгүүлчид сонгуулийг сурвалжлахдаа баримтлах дараах зарчмуудыг тохиролцсон юм.

- зөвхөн нотолгоотой баримтад тулгуурласан мэдээлэл түгээх,
- өөрийн үзэл бодлоор сурвалжлахгүй байх, аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх, эс өгөхийг уриалахгүй байх,
- сонгуулийн үр дүнд нөлөөлөхгүйц шударга бус үйлдлийг нуун дарагдуулахгүй байх,
- төр засгаас санхүүжүүлдэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төлбөртэй ба төлбөргүй сурталчилгааг нийтэд ойлгогдохуйц ялган зааглах,
- олон нийтийн санал асуулгын дүнг ашиглахдаа эх сурвалжийг дурдах,
- тухайн нийтлэл, нэвтрүүлгийг бичсэн, бүтээсэн сэтгүүлч нэрээ тавих,
- ноцтой, далд баримтыг илчилсэн тохиолдолд эх сурвалжаа нууцлах,
- мэргэжлийн алдаа гаргасан бол залруулгыг шуурхай хийх зарчмыг баримтлахаар тохиролцов¹.

Хэвлэлийнхэн энэхүү зарчмуудаа ерөнхийдөө баримталж ажилласан гэж үзэж болох юм. Харин сонгуулийн сурталчилгааны төгсгөл рүү хэвлэлийн мэдээлэл нилээд ширүүн өнгө аястай болсон юм. Засгийн газрын тэргүүн, МАХН-ын дарга Н. Энхбаяртай холбогдуулан "Дарангуйлагч" өгүүлэл сонгуулийн өмнөх орой зохиогчийн нэргүйгээр "Өдрийн сонин"-нд нийтлэгдсэн нь тохиролцсон зарчмыг хэтэрхий зөрчсөн жишээ болсон юм².

Сонгууль зарлал. Улсын Их Хурлын 2004 оны 04 сарын 8-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор УИХ-ын сонгуулийг 2004 оны 06 сарын 27-ны өдөр явуулахаар товлож, 2004 оны 04 сарын 12-ны өдрөөс сонгуулийн зохих бэлтгэл ажлыг эхлүүлэхээр болов. УИХ сонгуулийн төсвийг 696.578.660 төгрөг байхаар тогтож, 2004 оны улсын батлагдсан төсвөөс гаргахаар болов. Парламент 04 сарын эхээр сонгуулийн явцын болон зардлын талаарх мэдээллийг цаг хугацаатай нь өдөр тутмын сонинд нийтэлсэн³ нь иргэн бүр сонгуулийн үйл явцын талаар хангалттай мэдээлэл авах боломжтой болжээ.

Сонгуулийн бэлтгэл ажлыг "УИХ-ын сонгуулийн хууль"-ийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) удирдан явуулав. Ж. Ядамсүрэнгээр удирдуулсан Сонгуулийн ерөнхий хороо нь хуулиар нийт 11 гишүүнтэй. МАХН-ын гишүүд давамгайлсан УИХ 2004 оны 04 сарын 8-ны өдөр СЕХ-ны зарим гишүүдийг өөрчлөх тогтоол гаргаж АН-ын талд илүү ойр гишүүд болох Ч.Амарболд, Ч.Даваасүрэн, Д.Намсрай, Н.Түмэндэмбэрэл нарын оронд П.Бямбацэрэн, Б.Очирбат, Д.Сандаг-Очир, Ч.Хүрэлбаатар нарыг нөхөн сонгов⁴. Шинэ гишүүд бүгдээрээ МАХН-ын гишүүн буюу тус намын талыг баримтлагчид байлаа. МАХН-ын талынхан СЕХ-нд зонхилж байгаа тухай яригдахад СЕХ-ны дарга Ж.Ядамсүрэн нэгэн сонинд өгсөн ярилцлагадаа СЕХ-ны гишүүд ажиллах хугацаандаа намын гишүүнчлэлээс түдгэлзсэн байдаг гэж тайлбарлав⁵.

ямар өөрчлөлт оруулах вэ?, *Зууны Мэдээ*, 2004.05.01.

¹ Сэтгүүлчид сонгуулийн үеэр баримтлах зарчмаа тохиров, *Зууны Мэдээ*, 2004.04.15.

² Дарангуйлагч, *Өдрийн сонин*, 2000.06.25.

³ *Өнөөдөр*, 2004.04.07, *Өдрийн сонин*, 2004.04.09.

⁴ Улсын Их Хурлын тогтоол, *Өдрийн сонин*, 2004.04.09.

⁵ Ж. Ядамсүрэн, Сонгогч бүрийн санал төрд хэрэгтэй, *Өдрийн сонин*, 2004.04.27.

Сонгуулийн хороодын бүрэлдэхүүн: СЕХ нь түүний удирдлага дор ажиллах нийтдээ 76 тойргийн хороодоос бүрдэнэ. Ийм тойргийн хороод нь долоо, ес, эсвэл арван нэгэн гишүүнтэй байх ба нэг нарийн бичгийн дарга бүхий даргатай байна. Энэхүү тойргийн хороодын бүрэлдэхүүнийг 04 сарын 27-ны өдрийн хэвлэлд нийтэлсэн байна¹. Хэвлэлд мэдээлснээр, тойргийн хороодод МАХН-ын гишүүд (37,5%), "Эх орон-Ардчилал" эвсэлд нэгдсэн гурван намын гишүүд (34,7%), бусад нам, нам бусчууд (26,1%) ажиллах болжээ². Хороодын дарга, нарийн бичгийн дарга нарын албан тушаал МАХН-ын гарт байна гэж сөрөг хүчнийхэн гомдоллосон байна. Нийт 76 сонгуулийн тойргийн хороодын дарга нарын 69 нь МАХН-ын гишүүд төдийгүй тойргийн хороон дарга, бас нарийн бичгийн дарга нь хоёулаа МАХН-ын гишүүн 36 тойрог байв. Сонгуулийн бэлтгэл, сонгуулийн санал хураах ажилд тойргийн хороодын гишүүдийн зэрэгцээ хороодод нийт 17.000 хүн сонгуулийн туслагчаар оролцсон юм. Улс даяар 76 тойргийн хороонд 346 салбар хороо ажиллахаар зохион байгуулагдсан ба хэсгийн 1706 хороог бий болгожээ. Хот, хөдөөгийн ИТХ-ууд 04 сарын 22-ноос өмнө нийт сонгогчдод салбар болон хэсгийн хорооны хаягийг мэдээлсэн байна. Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо хөдөөд тойрог тутамд 15.000-20.000 орчим байсан бол Улаанбаатар хотод 25.000-30.000 байлаа³.

Сонгогчдын нэрийн жагсаалт. "УИХ-ын сонгуулийн хууль"-д зааснаар сонгогчдын нэрийн жагсаалтыг сум, дүүрэг, баг, хорооны засаг дарга хариуцах ажээ. Хуульд "...сонгогчдын нэрийн жагсаалтад түүнийг үйлдэх үед сонгуулийн тухайн хэсэгт буюу түр оршин суугаа бүх сонгогч"-ыг сонгогчдын нэрийн жагсаалтад бичихээр заажээ. Нэрийн жагсаалтад сонгогчийн нэр, овог, нас, оршин суугаа газрын хаяг, иргэний паспортын болон регистрийн дугаарыг бүртгэнэ. Цагдаа, эмнэлэг, амралт, сувиллын газрын удирдлагууд сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд шаардагдах мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй гэж хуульд тусгаснаас үзэхэд "түр оршин суугч" гэсэн ухагдахуун хичнээн өргөн утгаар хэрэглэгдэж буй нь тодорхой юм. Хуульд цааш нь: "Сонгогч санал авах өдрөөс өмнө өөр тойрог, хэсэгт шилжвэл сонгуулийн хэсгийн хорооноос шилжүүлэг авч сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулан, очсон газрынхаа сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлнэ."⁴ гэж заажээ.

Сүүлийн жилүүдэд Монголд иргэний үнэмлэхийг сольж байгаа билээ. Сонгуулийн өмнөх орой Монголчуудын 97 хувь нь иргэний шинэ үнэмлэхээ гардаж авсан байлаа. СЕХ-ны мэдэгдсэнээр бол 50.000 иргэн ийм төрлийн бичиг баримтаа авч чадаагүй байгаа бөгөөд тэдний "ихэнх нь шаардлагатай үйлчилгээний хураамж төлөх төлбөрийн чадваргүй хүмүүс" байсан гэж СЕХ-н дарга Ж.Ядамсүрэн тайлбарлав. Мөнгөний эх үүсвэрийг Засгийн газраар шийдүүлж, аль болох үнэгүй олгуулах боломжийг судлахыг Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн даргад даалгасан байна⁵. Бүртгэл нь асуудалтай байгаа бусад хүмүүсийн ихэнх нь сүүлийн жилүүдэд нийслэл рүү нүүж ирээд бүртгэлийн хураамжаа төлөх чадваргүйн улмаас бүртгүүлээгүй Улаанбаатар орчмын гэр хорооллынхон байлаа.

Нам, эвслийн сонгуулийн оролцоо. СЕХ-ны мэдээлсэнээр 04 сарын 23-ны өдрийг хүртэл 11 нам сонгуульд оролцохоо мэдэгдээд байв. Ардчилсан нам, Эх орон-Монголын Ардчилсан Шинэ Социалист Нам, мөн Иргэний Зориг-Бүгд Найрамдах Нам "Эх орон-Ардчилал" эвсэлд багтав. Найман нам өөрийн төлөөллөөр сонгуульд оролцохыг эрмэлзэв⁶. Монголын Эмэгтэйчүүдийн Нэгдсэн

¹ Улсын Их Хурлын 2004 оны тойргийн хорооны бүрэлдэхүүн, *Зууны Мэдээ*, 2004.04.27

² Хувь хэмжээг: Ж. Ядамсүрэн, Сонгогч бүрийн санал төрд хэрэгтэй, *Өдрийн сонин*, 2004.04.27.

³ *Зууны Мэдээ*, 2004.04.13.

⁴ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, Улаанбаатар 1992, х. 11

⁵ Ж. Ядамсүрэн, Сонгогч бүрийн санал төрд хэрэгтэй, *Өдрийн сонин*, 2004.04.27.

⁶ 1. МАХН, 2. Монголын Ногоон Нам, 3. Монголын Уламжлалын Нэгдсэн Нам, 4. Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам, 5. Монголын Либерал Ардчилсан Нам, 6. Монголын Иргэний Ардчилсан Шинэ Либерал

Нам заасан хугацаанд Улсын Дээд Шүүхэд бүртгүүлээгүй учраас сонгуульд оролцох эрх аваагүй юм.

Нэр дэвшигчдийн тодруулга. Нэр дэвшигчдийг тодруулах ажил МАХН, “Эх орон Ардчилал” эвслийн аль алинд нь дотоодын хүчтэй тэмцэл дунд явагдсан юм. Н. Энхбаяр тэргүүтэй МАХН-ын удирдлага сонгуулийн бэлтгэл ажлын явцад (СЕХ-ны товоор 05 сарын 27 хүртэлх хугацаанд) нам дотроо нилээд эсэргүүцэлтэй тулгарсан байна. Н.Энхбаяр, Ж. Гүррагчаа нарын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж намын доторх “Шударга ёс” бүлгийн ахлагч Г. Баярсайхан мэдээлэл хийв. Тэрээр сөрөг хүчний сонинд “Н. Энхбаяр намын дотоод ардчиллыг устгаж, намыг дарангуйлагч нам болгон хувиргасан” гэж байр сууриа илэрхийлэв. МАХН-ын гишүүн сонгуулийн бэлтгэл ажлын ийм эмзэг цаг үед иймэрхүү тайлбар хийсэнд хариу барихаас өөр аргагүйд хүргэсэн юм. Үүнээс үүдэн нийслэл хот Улаанбаатар дахь МАХН-ын Хяналтын хороо 2004 оны 05 сарын 12-ны өдөр Г. Баярсайханыг намаас хасах тогтоол гаргасан юм. Тогтоолд: “Нэг. МАХН-ын нэр хүнд, эв нэгдэл, үйл ажиллагаанд хохирол учруулсан Г. Баярсайханыг МАХН-ын дүрмийн нэгийн 4 дэх заалтын дагуу МАХН-ын гишүүнээс хассугай.”¹ гэжээ. Энэ хасалт бусад бүх шүүмжлэгчдэд айхтар анхааруулга болсон юм (Баярсайхан өөрийнх нь бүлэгт 1500 гаруй гишүүд багтдаг хэмээжээ).

Хэдийгээр МАХН-ын удирдлага Бага хурлын гишүүдээсээ өмнө дурьдсан үүрэг хариуцлагын батламжаа дагахыг шаардсан боловч УИХ-ын гишүүн асан зарим гишүүд энэ жилийн сонгуульд тэдний нэрийг гаргаж ирэхгүй гэдэгтэй санал нийлээгүйн улмаас зөрчилдсөн байна. Жишээ нь, сонгуулийн 23 дугаар тойргийг өдийг хүртэл УИХ-д төлөөлж ирсэн МАХН-ын бүлгийн Д.Оюунхорол батламжаа зөрчиж, энэ жилийн сонгуульд бие дааж нэр дэвшин бүртгүүлжээ. Намын удирдлага ч хатуухан хариу барьж Д.Оюунхоролыг намаас хассан байна. Намаас хасах тогтоолд: “1. МАХН-ын дүрмийн 3. 2, 3. 3-д заасан намын гишүүний үүргээ биелүүлээгүй намын бодлого, эв нэгдэлд харш үйл ажиллагаа явуулсан гишүүн Дуламсүрэнгийн Оюунхоролыг МАХН-ын дүрмийн 18-ын “Е” заалтыг үндэслэн МАХН-ын гишүүнээс хассугай. 2. Намын гишүүнээс хасагдсан Д. Оюунхоролын тухай мэдээллийг албан ёсны тайлбартайгаар намын хамт олонд хэвлэл мэдээллээр мэдэгдсүгэй.”²

МАХН-ын бие дааж нэрээ дэвшүүлсэн бусад гишүүдийг ч намаас хасжээ. Үүнд, Ч.Рахмет (сонгуулийн 5 дугаар тойрог/ Баян-Өлгий аймаг), А.Төмөр-Очир (сонгуулийн 31 дүгээр тойрог/ Сүхбаатар аймаг) нар оров.

Намаас ийнхүү хассан нь сонгогчдын сэтгэлд сэв суулгав. Олон хүн социализмийн үеийн сахилга бат тооцдог иймэрхүү механизмийг тод санаж байлаа. Бас МАХН-ын “Үнэн” сонинд нийтлэгдсэн тогтоолын үг хэллэг, “намын бодлого, эв нэгдэлд харш үйл ажиллагаа” гэх мэт тодотгол нь МАХН-ын түүхэнд дэх таагүй үеийн хуудсыг эргэн бодоход хүргэж байлаа. Ийм үйл явдлуудын дараагаар зарим сонгогчид өөрийн сонголтоо дахин нягталж үзэхэд хүргэсэн байхыг ч үгүйсгэх газаргүй юм.

МАХН-ын намаас хасах арга хэмжээний дараа АН бас бие дааж нэр дэвшсэн гишүүдээ намаасаа гаргаж эхэлсэн нь иргэдийн гайхшралыг терүүлж орхисон юм. Үүнд дараах гишүүд хамрагдав: Ч.Чулуунбат (сонгуулийн 9 дүгээр тойрог/ Баянхонгор аймаг), С.Билэгсайхан (сонгуулийн 16 дугаар тойрог/ Дорнод аймаг), А.Булган (сонгуулийн 22 дугаар тойрог/ Завхан аймаг), Я.Санжмятав (сонгуулийн 23 дугаар тойрог/ Завхан аймаг), А.Баттөр (сонгуулийн 42 дугаар тойрог/ Ховд аймаг), Д.Одхүү (сонгуулийн 55 дугаар тойрог/ Орхон аймаг), Д.Хувьтөгөлдөр (сонгуулийн 59 дүгээр тойрог/ Улаанбаатар), Д.Эрдэнэбат

Нам, 7. Монголын Бүгд Найрамдах Нам, 8. Монголын Нэгдсэн Эмэгтэйчүүдийн Нам

¹ Нийслэлийн МАХН-ын хяналтын хорооны тогтоол, *Үнэн*, 2004.05.13.

² Д. Оюунхоролыг МАХН-аас хаслаа, *Үнэн*, 2004.05.22.

(сонгуулийн 60 дугаар тойрог/ Налайх, Багануур), Р.Амаржаргал (сонгуулийн 64 дүгээр тойрог/ Улаанбаатар). Сөрөг хүчний хэвлэлүүд МАХН-ын намаас хассан арга хэмжээний талаар тайлбарлан бичиж, хасагдсан хүмүүсийг янз бүрээр ярилцлагад урьж байсан тэр үедээ харин АН-ын гишүүдээ хассан тухай бараг үг дуугараагүй юм. Зөвхөн “Ардчилсан Холбоо” Эвслийн засгийн газрын хамгийн сүүлчийн Ерөнхий сайдаар ажиллаж байсан Р. Амаржаргал л ядмагхан ярилцлага өгсөн байлаа.

Хачирхалтай нь МАХН, АН хоёрын аль аль нь нэр бүхий гишүүдээ намаас хассан тухайгаа СЕХ-нд мэдээлээгүй байна. Үүнээс үүдэн СЕХ УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг нийтэд зарласан нэрийн жагсаалтад дээрх бие даагчдын намын харъяаллыг нь бичсэн байсан ба аль ч нам нь тэднийг намын харъяаллаасаа хассан тухай албан ёсны тогтоолоо ирүүлээгүй гэж мэдэгдсэн юм. МАХН-ын намаасаа хассан энэ үйлдэл нь намын удирдлага сонгуульд *нэгдсэн нэг бодлогоор оролцох нь чухал* гэж үзэж байсантай холбоотой хэмээн дотор нь байдаг хүрээнийхэн таамаглаж байлаа. АН-ын хувьд энэ нь арай өөр байсан байх магадлалтай. МАХН-ын ялах магадлал өндөртэй нэр дэвшигчдийн тойрогт АН-д ойр бие даасан нэр дэвшигчдийг уралдуулж, “усыг нь юүлэх” стратеги боловсруулсан байж ч болох бөгөөд энэ нь сонгуулийн дүн болон дараа дараагийн алхмуудаар нь батлагддаг.

Сонгуульд нэрээ дэвшүүлэх хэн боловч намдаа санхүүгийн дэмжлэг болгон мөнгө төлөх шаардлагатай тулгарч байв. Энэ нь ерөнхийдөө намуудын маш хязгаарлагдмал санхүүжилттэй холбоотой байдгийг харуулж байна. Харьцангуй төвийг сахисан (Ерөнхийлөгчид ойр учраас) өдөр тутмын “Өнөөдөр” сонины мэдээлснээр, зарим намууд, тухайлбал АН, өөрийн нэр дэвшигчдээсээ хандив авч байлаа. Хандивийн ханш 05 сарын дунд үед хөдөөгийн нэг тойрог 20-30 сая төгрөгт хүрсэн ажээ. Ийм жишээ гэвэл “Өнөөдөр” сонины мэдээлснээр АН-ын идэвхтэн Баабар Дархан-Уул аймагт тойрог авахын тулд 20 сая төгрөгийн хандив төлсөн гэх ажээ. Улаанбаатар дахь тойргууд илүү “амттай” учраас хотын тойргийн хандивийн хэмжээ хавьгүй өндөр байсан аж. “Өнөөдөр”-т бичснээр бол бизнесмэн Г. Батхүү (АПУ компанийн захирал) Улаанбаатарт нэр дэвшихийн тулд 150 сая орчим төгрөг төлсөн гэх юм¹. Ийм их хэмжээний мөнгөгүй АН-ын зарим идэвхтнүүд нэрээ дэвшүүлэхээс татгалзсан бодит явдал нь бизнесмэнүүдэд аятай нөхцөл болж өгчээ.

“Эх орон-Ардчилал” эвслийнхэн сонгуулийн тойргоо эвсэлд багтсан гурван намд хуваах гэж халуухан маргаан үүсгэв. 2004 оны 05 сарын 12-ны өдөр тохиролцоонд хүрч АН-д 50 тойрог, Эх орон-МАШСН-д 21 тойрог, ИЗБНН-д 5 тойрог хуваарилсан юм².

Нэр дэвшигчдийн бүртгэл. СЕХ 05 сарын 27-ны өдрийг хүртэл 7 нам, 1 эвсэл болон бие даагчдыг бүртгэж нэр дэвшигчийн үнэмлэхийг нь гардуулжээ. Анх 339 хүн нэрээ дэвшүүлснээс сонгуулийн тойргийн хороод 262 хүнийг бүртгэжээ³. Бүртгэгдээгүй хүмүүс нь хууль зөрчсөн, баримт материал дутуу, намын харъяаллын асуудлаа шийдээгүй, мөн бие даан нэр дэвшихийг нь дэмжсэн 801 хүний гарын үсгийг бүрэн цуглуулж чадаагүй зэргээс шалтгаалжээ⁴.

¹ Р. Эмүжин: Наймаа ба улс төр, *Өнөөдөр*, 2004.05.13.

² АН-д сонгуулийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 11, 13, 18, 19, 20, 21, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 44, 45, 46, 47, 49, 50, 51, 52, 53, 56, 58, 61, 63, 65, 66, 68, 70, 71, 74, 75, 76, Эх орон-МАШСН-д 8, 9, 12, 14, 15, 23, 33, 36, 42, 43, 48, 54, 55, 57, 59, 60, 62, 67, 72, 73, ИЗБНН-д 10, 16, 17, 22, 69-р тойргууд тус тус оногдов. “Эх орон-Ардчилал” эвсэл тойргуудаа эцэлсэн тохирлоо, *Өдрийн сонин*, 2004.05.13-оос үзнэ үү.

³ УИХ-ын сонгуульд 339 хүний нэр дэвшсэнээс 262-ыг нь бүртгэжээ, *Өдрийн сонин*, 2004.06.01.

⁴ СЕХ энэ үндэслэлээр Монголын Залуучуудын Намын (энэ нам Дээд шүүхэд шинэчлэн бүртгэгдээгүй юм) бүх 62 нэр дэвшигч, Эх орон-Ардчилал эвслийн 76 нэр дэвшигчдийн 1 (Х. Хулан), Монголын Ногоон Намын 11 нэр дэвшигчдийн 1, Монголын Уламжлалын Нэгдсэн Намын 12 нэр дэвшигчдын 2, Монголын Либерал Намын 8 нэр дэвшигчдын 2, Монголын Бүгд Найрамдах Намын 43 нэр дэвшигчдийн 4-ийг нь болон 22 бие даагчдаас 4 хүнийг бүртгэхээс татгалзсан байна.

Бүртгүүлсэн намуудаас МАХН 76, "Эх орон-Ардчилал" эвсэл (АН, Эх орон-МАШСН, ИЗ-БНН) 76, Монголын Бүгд Найрамдах Нам (МБНН) 35, Монголын Ногоон Нам (МНН) 6, Монголын Уламжлалын Нэгдсэн Нам (МУНН) 9, Монголын Либерал Нам (МЛН) 4, Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам (МҮЭНН) 23 хүний нэрийг дэвшүүлжээ. УИХ-ын сонгуульд 15 бие даагч нэрээ дэвшүүлсэн байна¹. Өнгөрсөн сонгуультай харьцуулж үзэхэд тойрог тус бүрт өрсөлдсөн нэр дэвшигчдийн тоо дунджаар хоёроор цөөрсөн байлаа. Нийт нэр дэвшигчдийн 36 нь эмэгтэй, дундаж нас нь 43,7, 40-50 насны нэр дэвшигчид 148, мөн 50-60 насны нэр дэвшигчид 53 байв².

Нэр дэвшигчийн нэрээ эгүүлэн таталт. Нийт 21 нэр дэвшигч хуулиар заасан хугацаанд нэрээ эгүүлэн татсан байна³. БНН 2, МНН 1, Эх орон-Ардчилал эвсэл 1, МУНН 1 хүний нэрийг шинээр дэвшүүлсэн. Сонгуулийн ерөнхий хорооны болон шүүхийн шийдвэрээр нэр дэвшигч Т.Баярхүү (сонгуулийн 44-р тойрог, МУНН), Х. Хулан (сонгуулийн 57-р тойрог, Эх орон-Ардчилал эвсэл) нарын нэрийг дахин дэвшүүлсэн юм.

Сонгуулийн кампани. МАХН Монголын түүхэнд урьд өмнө гарч байгаагүй тийм хүчтэй сонгуулийн тэмцлийг явуулахдаа 1-рт реклам самбарын хэлбэрээр, 2-рт электрон хэлбэрээр, 3-рт сонгуулийн шоу, 4-рт улсын болон намын хэвлэл (Зууны Мэдээ, Үнэн сонин, тэрчлэн хамтрагч талын "Чөлөөт Хэвлэл")-ээр, 5-рт сонгуулийн сурталчилгааны материалыг айл өрхөөр тараах зэрэг тэдэнд байгаа бүх боломжийг ашигласан юм. Сонгуулийн кампанит ажлаа МАХН тасралтгүй явуулж, өөрсдийгөө улс орны болон залуучуудын ирээдүйд чиглэсэн шинэлэг социалист нам хэмээн харуулахыг зорьж байв. Нийслэл Улаанбаатар хотын хамгийн гол бүх гудамжуудаар МАХН-ын сурталчилгааг ил тодоор байрлуулсан ба хотын бараг бүх сурталчилгааны самбаруудад зөвхөн МАХН-ын зурагт хуудсыг нааж, намын идэвхтэй туслагч нар айл өрхөөр явж, өндөр үнэтэй цаасаар хэвлэсэн намын танилцуулгыг их хэмжээгээр тараажээ. Тэдний зурагт хуудсууд дээр "Социнтернийн гишүүн МАХН-дэлхийд өргөмжлөгдсөн Монгол нам", "МАХН-Шинэ үе МАХН-ыг сонгож байна", "МАХН- Аав, ээж, ах, эгч, чиний, миний нам", "МАХН-Монголын гэрэлт ирээдүй", "МАХН-Хөгжлийн төлөө, Ардчилалын төлөө, Монголын төлөө, Таны төлөө", "МАХН-Таны төлөө, тантай хамт", "МАХН-Мянганы зам-хөгжлийн зам", "МАХН-Аав, ээж, бид гурвын алдаагүй сонголт", "МАХН-Газар-Миний өмч", "МАХН-манай нам, миний нам" гэх мэт уриа лоозонгууд бичигдсэн байлаа.

Ерөнхий сайд Н. Энхбаярын зурагт хуудас маш олон байсан ба түүний АНУ-ын Ерөнхийлөгч Ж. Буштай уулзаж буй, НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннантай, эсвэл Монголын алдартай сумо бөхтэй хамт авахуулсан, тэрчлэн НҮБ-ын Чуулганы илтгэлийн индэр байгаа зэрэг зургуудыг харж болж байв. МАХН-ын сурталчилгаа юуны өмнө залуучууд руу чиглэсэн байсан нь эдгээр зурагт хуудсуудаас ойлгогдож байлаа. Жишээлбэл нэг дээр нь "МАХН – бидний дуу хоолой нэг" гэсэн уриатай Монголын нэртэй поп хамтлаг, дуучдыг үзүүлсэн байв. Мөн буддизм ч сонгуулийн өрсөлдөөнд оролцох ёстой байсныг МАХН-ын сурталчилгаанаас харж болж байв. "МАХН - Өвөг дээдсээс уламжлагдсан өв, соёлоо дээдэлъе" гэсэн уриатай, Мэгзэд жанрайсаг бурхны өмнө зогсох лам хүүхдийн зургийг ч харлаа. Сонгуулийн кампанийн явцад МАХН анхны зурагт хуудсуудаа шинэчилж сольсон ба тэдгээр нь сонгогчдыг материаллаг амлалтаар татахад чиглэгдэж байв. Жишээлбэл шинээр гэр бүл бологсод 500.000 төгрөг өгнө, 145.000 ажлын байр шинээр бий болгоно

¹ Нэрээ эргүүлэн татлаа, *Зууны Мэдээ*, 2004.06.19.

² Ч. Чулуун, УИХ-ын сонгуульд 339 хүний нэр дэвшсэнээс 262-ыг нь бүртгэжээ, *Өдрийн сонин*, 2004.06.01.

³ МБНН-аас 5, МУНН-аас 3, МНН-аас 3, Эх орон-Ардчилал эвслээс 1, МЛАН-аас 2 нэр дэвшигчид, бие даагчдаас 2 хүн нэрээ эргүүлэн татав. Харьцуул: УИХ-ын 2004 оны сонгуульд нэр дэвшигчээс 15 нь нэрээ эргүүлэн татлаа, *Өдрийн сонин*, 2004.06.10, Сүүлд нэмж МНН-аас 2, МҮЭНН-аас 3 нэр дэвшигчид өрсөлдөхөөс татгалзав. Нэрээ эргүүлэн татлаа, *Зууны Мэдээ*, 2004.06.19.

(мөрийн хөтөлбөрийг үзнэ үү) гэх мэт амлалтуудыг нэрлэж болно. Мөн үзвэрийн сурталчилгаанд маш үнэтэй сонгуулийн шоунуудыг зохион байгуулсан юм.

МАХН-ын үзэл суртлын машин хэдий сайн идэвхжих тусам түүнээс гарах үр дүн өөрт нь улам эсрэгээр нөлөөлсөөр байв. МАХН-ын сурталчилгааны ажиллагааг шүүмжлэх монголчуудын тоо байнга өссөн юм. Мөн сонгуулийн сурталчилгааны зурагт хуудсуудад зарцуулсан мөнгөний хэмжээ олон нийтэд мэдээлэгдэж байлаа. Хүмүүс "хайран ч мөнгө" хэмээн халаглаж байв. Нийслэлийн маш олон иргэд энэ мөнгийг Улаанбаатар хотын эвдрээд удаж байгаа замын засварт зарцуулсан бол дээр байсан гэсэн саналтай байв. Эндээс үүсэлтэй нэгэн наргиа үг гарсан нь: "Улаанбаатарт хоёр там байдаг: Нэг нь Улаанбаатарын зам, нөгөө нь нам". Хотын удирдлага сонгуулийн өмнөхөн зарим нэг замыг засуулж билээ.

Сөрөг хүчин нийслэл хот дахь сурталчилгаанд сонгуулийн кампанийн төгсгөл үед цөөхөн тооны зурагт хуудастайгаар гарч ирсэн юм. АН-ын хамгийн түгээмэл зурагт хуудаст тэдний лидерүүдийн эгнээ байх ба (М.Энхсайхан, Р.Гончигдорж, Баабар, Да.Ганболд, Э.Бат-Үүл, Лу.Болд, Л.Гүндалай, Ц.Элбэгдорж) тэд "хөгжил ба дэвшил"-ийг амлаж байв. Сөрөг хүчин ч мөн улсын төсвөөс давсан материаллаг амлалтуудыг хийж байсан. Тэдний хамгийн гол амлалт нь "18 нас хүртэлх бүх хүүхдэд сар бүр 10 мянган төгрөгийн 'итгэлийн мөнгө' олгоно" гэж байсан юм. Гэвч 18 хүртэлх насны нэг сая гаруй хүүхэд залуучуудтай Монгол орны хувьд энэ амлалтыг биелүүлэхийн тулд Монгол Улсын төсвийн нэлээн том хэсгийг зарцуулах шаардлагатай болж буй юм.

Хэдийгээр сөрөг хүчний мэдээллээ түгээх боломжийг МАХН-тай харьцуулахын аргагүй ч "Эх орон-Ардчилал" эвслийн нэр дэвшигчид Улаанбаатар хот орчмоор сонин хэвлэл болон электрон хэлбэрээр (юуны өмнө хувийн радио телевиз) өөрсдийгөө хангалттай танилцуулах бололцоотой байв. Монголд өнөөгийн байдлаар өдөр тутмын зургаан сонин гардаг. Тэдгээрээс "Өдрийн сонин", "Өнөөдөр", "Монголын Мэдээ" зэрэг гурван сонинд (Өдөрт хэвлэгдэх нийт тоо 19.568 ширхэг. Энэ нь өдөрт хэвлэгдэх нийт бүх сонин 49,8 хувьтай тэнцэнэ.) "Эх орон-Ардчилал" эвслийн нэр дэвшигчид болон тэдний мөрийн хөтөлбөрийг тогтмол танилцуулж байлаа. Түүн дээр шар хэвлэл дэх маш олон төрлийн сурталчилгааны материалууд орно. МАХН-ын засаглалын үед нийтэлсэн нийтлэлийнхээ (гэхдээ ихэнхдээ худал хуурмаг, буруу зүйлд уриалан дуудсаны) төлөө шүүхэд дуудагдаж байсан шар хэвлэлийн сэтгүүлчид АН-ын талд зогсож байлаа. Мөн хувийн радио станцууд сөрөг хүчнийхэнд нэвтрүүлэг сурталчилгааны боломжуудыг гаргаж байв. Эндээс сөрөг хүчнийхний сонгуулийн тэмцэл Улаанбаатарын хувьд хэвлэл мэдээллийн дэмжлэгийг бүрэн авах боломжтой байсан нь харагдаж байв. Сөрөг хүчнийхэн хэдий МАХН шиг "материаллаг тулаан" хийгээгүй ч сонгогчдоос эерэг үнэлэмж хүртэж байлаа.

Нийт сонгогчдын талаас илүү хувь нь амьдардаг хөдөө, орон нутагт өөрсдийгөө танин мэдүүлэх нь сөрөг хүчний хувьд хүндрэлтэй байсан. Хөдөөгийн ард түмний ихэнх нь засгийн эрх барьж байсан МАХН-ын мэдлийн үндэсний радио телевизээр цацагдаж байсан сонгуулийн сурталчилгааны мэдээллийг хүлээж авч байлаа¹. Сонин хэвлэл бол хөдөө орон нутагт бараг нөлөөгүй. Жилд хэвлэгдэх бүх сонингийн зөвхөн 2,6% нь л хөдөөд түгээгддэг. Тэгэхдээ юуны өмнө улсын байгууллагын албан ёсны хүрээнд л явагдана. Аймгуудад түгээгддэг орон нутгийн сонин хэвлэлийн мэдээллийн чанар муу учраас эх сурвалж болгон ашиглах боломжгүй байдаг юм. Хөдөө орон нутагт улс төрийн биечилсэн шууд харилцаа, уулзалт, мөн албан тушаалын уяатай харьцаа улс төрийн сонгуулийн дүнг ихээхэн шийддэг юм.

¹ Сонгуулийн кампанит ажлын санхүүжүүлэлтийн мониторинг төслийн явцын тайлан, Улаанбаатар, 2004.06.08.

Сонгуулийн мөрийн хөтөлбөр. Хоёр гол өрсөлдөгчийн сонгуулийн хөтөлбөр дээр анхаарлаа төвлөрүүлэх нь илүү үр дүнтэй болов уу. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хамгийн гол мессежүүд угтаа нийгэм, эдийн засгийн бодлого, гадаад бодлого болон арми/батлан хамгаалах бодлогын хүрээнд цацагддаг ч сонгогчдын хувьд зөвхөн нийгэм эдийн засгийн бодлого, ялангуяа бэлэн мөнгөний амлалт сонирхлыг нь илүү татаж байв.

Нийгмийн бодлого (боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл)

МАХН

Боловсрол; Хүүхдийг долоон наснаас сурьгуульд хамруулах, 11 жилийн сургалтыг нэвтрүүлэх, сургуулиас завсардсан хүүхдүүдэд нөхөн сургах сургалт зохиох, гурваас дээш хүүхэдтэй эмзэг гэр бүлийн нэг хүүхдэд сурах бичиг үнэгүй олгох, гадаад сурч буй оюутан, магистрант, докторантын тоог нэмэгдүүлэх,

Эрүүл мэнд; Сум орон нутгийн эрүүл мэндийн төвүүдийг түргэн оношлогооны тоног төхөөрөмжөөр тохижуулах, сум орон нутгийн эрүүл мэндийн төвүүдийг хэт ягаан туяаны оношлогооны тоног төхөөрөмжөөр тохижуулах, эмч нарыг сургах, аймаг бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдийн материаллаг баазыг сайжруулах, тэнд ажиллаж буй хүмүүсийн боловсролыг дээшлүүлэх, гадаадын хөрөнгө оруулагч, мэргэжилтнүүдийн дэмжлэгээр оношлогоо эмчилгээний нэг төвийг Улаанбаатарт байгуулах, эмнэлгийн давтан сургалтын системийг төгөлдөржүүлэх, эрүүл мэндийн даатгалын системийг төгөлдөржүүлэх

Хөдөлмөр эрхлэлт; 145,000 ажлын шинэ байр бүрдүүлэх, өндөр хөгжсөн орнуудад явуулах ажилчдын тоог нэмэгдүүлэх, эдгээр хүмүүсийн эрх сонирхлыг хамгаалах ажиллагааг идэвхжүүлэх, улсын болон төсвийн байгууллагад ажиллагсдын цалингийн доод хэмжээг инфляцийн төвшинтэй уялдуулан тогтоох + цалингийн болон хэрэглээний үний өсөлтийн харьцааг 1:1.5 болгох, 1995 оноос ба түүний өмнөх дараах тэтгэврийн хэмжээг тэгшитгэх, улсын тэтгэврийн даатгалын системийг төгөлдөржүүлэх, сайн дурын хувийн тэтгэврийн даатгалыг буй болгох, ажилгүйдлийн тэтгэмжийг хамгийн сүүлийн цалингийн 50 хувь хүртэл өсгөж ажилгүйдлийн даатгалд 5-аас доошгүй жилд төлөх.

Гэр бүл; Шинээр гэр бүл бологсдод 50.0000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх, шинээр төрсөн хүүхэд бүрт 100.000 төгрөгийн нэг удаагийн тусламж өгөх, гурваас дээш хүүхэдтэй айлыг олон хүүхэдтэй айлд тооцон жил бүр 100.000 төгрөгийн тэтгэмж өгөх, шинээр баригдах орон сууцны 2 хувийг өндөр настан тахир дутуу иргэдэд олгож байх, өмч хувьчлалаас бүрдэх хөрөнгийн 3 хувиар өндөр настныг дэмжих сан байгуулах, залуу хосуудын орон сууц худалдаж авах урт хугацааны зээлийн сангийн үйл ажиллагааг өргөтгөх, багш, эмч, цэргийн албан хаагч, цагдаа шүүх болон улсын өмгөөлөх албаны ажилтан мэтийн улсын албан хаагчдад орон сууц, эзэмшил газар худалдаж авах урт хугацааны зээлийг бүрдүүлэх

Эх орон –Ардчилал эвсэл

Гэр бүл; хүүхэд бүрт сард "Итгэлийн мөнгө" 10.000 төгрөг олгох, түүнийг шинэ засгийн газрын эхний 100 хоногт багтаан энэ мөнгийг олгох зохицуулалтыг хийх, залуу гэр бүлүүдэд газар эзэмших, хувьчилж авах зээлийн системийг бүрдүүлэх, 40.000 орон сууцны хөтөлбөр, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр орон сууцны үнийг бууруулах, татварт өрхийн зөвхөн нэг хүнийг хамруулах зарчмаар орлогын татварыг бууруулах, бага ба дунд орлоготой айл өрхүүдэд орон сууц барих урт хугацааны зээл олгох ба эдгээрийг хуулиар баталгаажуулах, орон сууц худалдаж авах үед банкуудын хөрөнгө оруулах

системийг тохиромжтой болгох, гэр хорооллуудыг цэвэр ус, цахилгаан, хий болон бохир усны шугамд холбох нөхцлийг бүрдүүлэх, газрыг иргэдэд үнэ төлбөргүй олгох

Эдийн засаг

МАХН

Бичил ба жижиг бизнесийн эрх зүйн орчинг бүрдүүлэх. аж ахуй, банк, санхүүгийн байгууллагууд болон иргэдийг үл хөдлөх хөрөнгийн худалдаанд саадгүй оролцох нөхцлийг бүрдүүлэх, мөнгө- төсөв-татварын бодлогоор дамжуулан зээлийн хүүг алхам алхмаар бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засгийн томоохон нэгжүүдийн хувьчлалыг үргэлжлүүлэх, хүнд суртал, зөвшөөрлийн асуудлуудыг бууруулж аж ахуйн нэгжүүдийн чөлөөтэй хөгжих боломжийг бүрдүүлэх, жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд урт хугацааны зээл, лицензээр дамжуулан тоног төхөөрөмж олгох, газар тариалан эрхлэх зорилгоор газар эзэмших өмчлөхийг дэмжих, газар тариалан эрхлэгчдэд машин техник, тоног төхөөрөмж авах зориулалтаар урт хугацааны боломжийн хүүтэй зээл олгох, аж ахуйн нэгж иргэдийн орлогын татварыг бууруулах, нэмүү өртгийн татварыг бууруулах, малчин болон мал эзэмшигчдэд оногдох орлогын татвар, бэлчээр ашигласны татварыг ялгаатай ангилан тогтоох, татварын системийг тохируулан шинэчлэх, татвар хураалтыг сайжруулах.

Эх орон –Ардчилал эвсэл

Лиценз зөвшөөрлүүдийг бууруулж, аж ахуйн нэгжүүдийн чөлөөт хөгжих боломжийг бүрдүүлэх, бүх малчин өрх айлыг таван жил татвараас чөлөөлөх, аж ахуйн нэгжийн татварыг шаталсан системд шилжүүлэх.

Гадаад бодлого

МАХН

Хөрш зэргэлдээ орнуудын хамтын ажиллагаа, найрсаг харилцааг бэхжүүлэх, сайн хөршийн харилцааг хөгжүүлж өргөтгөх; худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын салбарт хоёр талт харилцааг өргөтгөх; орос, хятад, Монгол Улсын хооронд танзит тээврийн гурван талт гэрээг хийх, худалдааны нөхцлийг хөнгөвчлөх, үнэ тарифийг бууруулах; өрнө, дорны хөгжилтэй орнуудын хамтын ажиллагаа болон харилцааг бэхжүүлэх, тэдгээр улс оронтой чөлөөт худалдааны гэрээ тохиролцоо хийх, АНУ–тай хийх нөхөрсөг харилцаа холбоог бэхжүүлж, хөгжүүлэн чөлөөт худалдааны гэрээ хэлцэл хийх, цаашдын хамтын ажиллагааны үндэс суурь болгон япон улстай олон талт нөхөрлөлийг хөгжүүлэх, улс төр эдийн засаг соёлын хүрээнд харилцаа холбоогоо хөгжүүлэх, худалдаа хөрөнгө оруулалтыг өсгөх гэрээ хэлцэл хийх, европын холбоотой хийх харилцаа холбооны төвшинг өсгөх; ази, латин америкийн улс орнуудтай хийх харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, НАТО-гийн “Энхтайваны төлөөх нөхөрлөл” хөтөлбөрт нэгдэх, ази номхон далайн болон зүүн хойд азийн бүс нутгийн хүрээний хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын терроризм, зохион байгуулалттай алан хядлага, хар тамхины худалдаа болон байгаль бохирдуулалтын эсрэг тэмцлийн хүрээнд хамтран ажиллах, зүүн европын улс орнуудтай уламжлалт харилцаа холбоогоо сэргээн хөгжүүлэх

Эх орон –Ардчилал эвсэл

Монгол Улсын иргэний сонирхлыг дэлхийн өнцөг булан бүрт хамгаалах, ард түмний амдралыг эдийн засгийн хувьд дээшлүүлэх үндсэн зорилгод түшиглэн гадаад бодлогыг уялдуулан явуулах, хөрш зэргэлдээ болон бусад улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх гадаад бодлогын уламжлалт шинж

чанарыг хадгалах, улс үндэстний тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэхийн хамт хөрш орнуудын болон олон улсын зах зээлийн боломжийг илүүтэй ашиглах, эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах бодлого барина, өөрийн улс орныг БНСУ-ын жишгээр хөгжүүлэх, монголд хэрэгжиж буй олон улсын төслүүдийн үр өгөөжийг дээшлүүлэх, олон улсын гэрээ хэлэлцээрийн дүнд далайд гарцгүй улс орнуудад олгогдсон тодорхой эрхүүдийг үр дүнтэй ашиглах

Батлан хамгаалах/ Аюулгүй байдлын бодлого

МАХН

Цэрэг армийн бүтэц, батлан хамгаалах системийг төгөлдөржүүлэх, орон нутгийн хамгаалалтын эрх зүй зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх, эдийн засгийн болон бүс нутгийн онцлогтой тохируулан цэргийн анги нэгтгэлийн байрлалт, бүтэц, тэдгээрийн хангамжийн зохицуулалтийн боловсруулалтын арга хэмжээг явуулах, олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаа (peace-keeping-missions)-нд монголын анги нэгтгэл оролцох эрх зүйн үндэслэлийг сайжруулах, улсын объектыг олон улсын терроризм болон террорист халдлагаас хамгаалах ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх, цэргийн насны залуусын боловсрол, эрүүл мэнд, эх оронч хүмүүжлийг сайжруулах, армийн зэвсэг техникийг шинэчилж сайжруулах, хөдөө орон нутагт чухал хэрэгцээт мэргэжилтнийг цэргийн албаас чөлөөлөх,

Эх орон –Ардчилал эвсэл

Энхийг сахиулах зэвсэгт хүчний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хилийн хамгаалалд илүү анхаарах, хилийн хамгаалалтын анги нэгтгэлүүдийн зэвсэглэлийг сайжруулах, байгаль хамгаалалтыг сайжруулах, иргэний хамгаалалтад онцгой анхаарал тавих, тагнуулын албыг шилдэг техник хэрэгслээр хангах, ажилчдыг өндөр төвшинд сургаж бэлтгэх, тагнуулын алба улс төрийн зорилгод үйлчилдэг байдлыг таслан зогсоох, улс орны аюулгүй байдалд ноцтой хохирол учруулсан бөгөөд улс төрийн шалтгаанаар дарагдаж буй хэргүүдийг нягтлан шалгах.

Сонгууль

2004 оны 06 сарын 24-нд явагдсан УИХ-ын сонгуулиар ийм дүн гарахыг бүр дотор нь байдаг хүрээнийхэн ч төсөөлж байсангүй. СЕХ-н дарга Ц.Ядамсүрэн сонгуулийн урьдчилсан дүнг танилцуулахад "Эх орон–Ардчилал" эвсэл, МАХН хоёр адил тэнцүү 36 суудал авсан байсан ба үүнд "Эх орон–Ардчилал" эвслийнхэн маш их баярлаж, харин МАХН-ынхны урам хугарсан билээ. УИХ-д МБНН нэг, бие даагчид гурван суудалтай болов. Зарим сонгуулийн тойргуудын санал тооллын дүн бүрэн гүйцэд ирээгүй байсан ч бүх зүйл торгон зүүн дээр тогтож байлаа. Бие даан ялсан гурван нэр дэвшигч улс төрийн цаашдын үйл явц, өрнөлд ямар том нөлөө үзүүлэхээр болсон нь хэн бүхэнд тодорхой боллоо. Хэдийгээр бие даан нэр дэвшсэн Я. Санжмятав, Д. Одхүү, Р. Амаржаргал нар өөрсдийг нь "хөөсөн" АН-ын эгнээнд багтдаг үе байсан ч АН-ын дарга М. Энхсайхан сонгуулийн дүн тодронгуут тэднийг эвсэлдээ нэгтгэн авсан юм. Нэгэн хэвлэлийн бага хурал дээр тэрээр тайлбарлахдаа гурван нэр дэвшигч Сонгуулийн хороонд бие даагчаар нэрээ дэвшүүлэн бүртгүүлж байхдаа ялсан тохиолдолд эвслийн талд орно хэмээн өөрт нь амлаж байсныг хэлэв. 2004 оны 06 сарын 29-ний өдөр АН "Эх орон–Ардчилал" эвслээс сонгогдсон хүмүүсийн нэрсийг жагсаан гаргахад нөгөө бие дааж УИХ-ын гишүүн болсон гурвын нэрсийг оруулсан байсан ба тэд ч үүнд тодорхой мэдэгдэл хийгээгүй нь М. Энхсайханы байр суурьтай нийцэж байгаа юм болов уу гэж үзэхэд хүргэсэн юм.

МАХН сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхөд маш хүнд байлаа. Хэвлэлийн бага хурал дээр тэд эвслийг сонгуулийн дүнд нөлөөлөх зорилгоор зарим тойрогт маш олон сонгогчдийг автобусаар зөөж оролцуулсан хэмээн өрсөлдөгчөө буруутгаж байсан юм. Эдгээр нь зөвхөн ёс зүйн үүднээс авч үзэхээс өөр аргагүй асуудал байсан бөгөөд сонгуулийн хуульд тухайн асуудлаар тодорхой заалт байгаагүй нь бодит амьдрал дээр иймэрхүү үйлдэл их бага хэмжээгээр хийх нэрмээс болсон юм. Сонгуулийн 24 ба 59-р тойрогт гарсан ийм зөрчлийн улмаас СЕХ сонгуулийн нийт 76 тойргоос 74 тойргийн сонгуулийн үр дүнг Ерөнхийлөгчид танилцуулсан билээ. Дээрх зөрчилтэй хоёр тойргийн асуудлыг шийдэх маш чухал анхны үүрэг даалгавар Монголд денгөж байгуулагдаад байсан Захиргааны шүүхэд оногдсон юм. Энэ хоёр тойргийн асуудал шийдэгдэх хүртэл МАХН 36, Эх орон-Ардчилал эвсэл 34, МБНН 1, бие даагчид 3 суудал авав.

Сонгуулийн оролцоо

Зарим нэг судалгааны байгууллагууд сонгуулийн оролцоо өмнөхөөс буурахаар байна гэж урьдчилан тооцоолж байсан нь биеллээ олоогүй юм. Энэ нь МАХН болон "Эх орон-Ардчилал" эвслийн бие биенийхээ эсрэг маш хүчтэй өрсөлдөөн явуулсантай холбоотой байж болох юм. Хоёр тал хоёул сонгогчдын саналыг гээхгүйн тулд тэднийг идэвхитэй татан оролцуулсан нь сонгуулийн оролцоо өндөр гарахад сайнаар үйлчилсэн болов уу. Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн 1.279.516 сонгогчоос 1.051.812 нь саналаа өгсөн (сонгуульд оролцоогүй хүний тоо 227.704) ба сонгуулийн оролцоо улсын хэмжээнд 82,2 %-тай гарав. 2000 оны сонгууль (82,43%), 2001 оны Ерөнхийлөгчийн сонгууль (82,9%)-тай харьцуулбал сонгуулийн оролцоо ер нь жигд байгаа юм.

Улаанбаатар болон аймгууд дахь сонгуулийн оролцоо (хувиар)

Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр + Дорноговь	Дорнод
83,61	86,53	84,16	83,07	89,89	83,60	83,35
Дундговь	Завхан	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв
85,41	88,10	84,05	87,62	90,46	82,06	74,60
Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Дархан-Уул	Орхон	Улаан-баатар
86,61	89,59	81,65	85,13	79,46	80,72	78,38

Эх сурвалж: Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Улсын Их Хурлын 2004 оны сонгуулийн нэгдсэн дүн, 2004 оны 07-р сарын 02-ны өдөр

Сүхбаатар аймгийн сонгогчид хамгийн идэвхтэй буюу 90,46 %-тай оролцсон ба энэ аймагт Санхүү эдийн засгийн сайд Ч.Улаан МАХН-аас нэр дэвшиж, 78,2%-ийн санал авч хамгийн өндөр үзүүлэлттэйгээр бүртгэгдсэн байна. Түүний энэ амжилт МАХН-ын удирдлага доторх улс төрийн байр суурь болон ирээдүйд хэн намыг удирдах вэ? гэсэн асуултад хүчтэй нөлөөлөх нь дамжиггүй. Хөдөө аймгуудад иргэд (нийт бүртгэгдсэн сонгогчид 768.971) дунджаар 84,97%-тай сонгуульд оролцсон бол Улаанбаатарт 79,52%, Дархан-Уул, Орхон аймагт (нийт бүртгэгдсэн 510.545) түүнээс 5,5% хувиар илүү байлаа.

УИХ-ын шинэ гишүүд

Одоогийн байдлаар МАХН 36, Эх орон-Ардчилал эвсэл 34 суудалтай байна. МАХН-ын бүлгийн гишүүдийн дундаж нас 48,5 бол "Эх орон-Ардчилал" эвслийнх 46,8 байгаа нь өнөөгийн улс төрийн элитүүдийн дундажыг насыг төлөөлж чадаж байна. Өөрөөх хэлбэл УИХ-ын "дундаж гишүүн" 1956 онд төрсөн бөгөөд амьдралынхаа 34 жилийг өмнөх социалист нийгмийн үед өнгөрүүлсэн байна. Тэдний бие хүний төлөвшил нь (гэр бүл, цэцэрлэг, сургууль, их дээд сургууль) юуны өмнө өөрчлөн байгуулалтын цаг хугацаа уур амьсгалын үеэр

бүрэлдэн тогтсон (энэ үед тэд 29-34 настай байв) байдаг. Хуучин ЗХУ-д боловсрол эзэмшсэн УИХ-ын гишүүдийн тоо урьдын адил өндөр хэвээр байна. Энэ харьцаа МАХН-ын бүлэгт 44,5%-тай байхад Эвслийн бүлэгт 61,7% байна. Монголд боловсрол эзэмшсэн УИХ-ын гишүүдийн хувь хэмжээ МАХН-ын бүлэгт 47,2% байхад Эвслийн бүлэгт 23,8%-тай гарчээ. Барууны үнэт зүйлсийг өөртөө шингээсэн гишүүдийн хувь хэмжээ Монголын нийгмийн хүлээн авах чадварын тэр л хэмжээтэй нийцэж байгаа юм.

Улаанбаатар хотод төрсөн УИХ-ын гишүүдийн эзлэх тоон үзүүлэлт 90-ээд оны үеэс тогтмол өссөн нэмэгдэж ирэв. Улс төрийн элитийн давхарга аль социализмийн үед Улаанбаатарт төвлөрч байсантай энэ нь холбоотой юм. Улаанбаатар хотод төрсөн албан тушаалтны тоо ирэх жилүүдэд улам өсөхөөр байна. Шинэ УИХ-ын гишүүдийн хувьд энэ үзүүлэлт МАХН-ын бүлэгт 19,5%, Эвслийн бүлэгт 35,3% байна. Гэхдээ эндээс МАХН хөдөө орон нутгийн ард иргэдтэй илүү сайн холбоо ажилладаг гэсэн дүгнэлт хийж үл болно. Тус намын хамгийн гол албан тушаалтнууд ч социализмийн үеэс Улаанбаатарт амьдарч байгаа юм. Улс төрийн элитүүд тодорхой хугацааны дараа Монголын нийгмийн хөдөөгийн хэсгээс улам тусгаарлагдаж, шийдвэр гаргах тодорхой албаа үргэлжлүүлэн хашивч хөдөөгийн ард иргэдээс сэтгэлгээний хувьд хөндийрөн, тэдний бүс нутгийн хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх чадвараа улам улмаар алдсаар байх болов уу гэсэн таамаглалыг энэ чиг хандлага төрүүлж байна. Нөгөө талаар, орон нутгийн иргэдийн хурлуудын хариуцлагатай албуудад тодорхой овгийнхон зонхилохоор байгааг мөн ажиглаж болно. Хөдөө орон нутгийн хөгжилд дээрх хоёр чиг хандлага маш их эрсдэл дагуулж байна. Уг санаа нь их зөв "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг зөвхөн гадаадын зээл тусламжийг татах суртчилгааны хэрэгсэл байлгах биш, ерөөсөө бүс нутгийг хөгжүүлэх хөгжлийн бодлогын чиг шугам болгон хэрэгжүүлэхээр болбол дээрх хүндрэлтэй үнэхээр тулгарна. Үүнийг гүйцэлдүүлье гэвэл ирээдүйд УИХ, орон нутгийн иргэдийн хурлууд хоорондын харилцаанд "Нутгийн зөвлөл"-ийг тухайн орон нутгийн бие төлөөлөгчийн үүрэгтэйгээр цоо шинэ холбогч болгон ажиллуулбал ямар вэ гэдгийг бодолцож үзвэл зүгээр болов уу.

Шинэ УИХ-ын нэг онцлог гэвэл гишүүдийн дунд маргаан байхгүй олон бизнесийн төлөөлөгчид байгаа явдал юм. Тэдний хувийнх нь компаниуд тус улсын хамгийн том компаниуд байдаг ба жишээлбэл Голомт банк (үүсгэн байгуулагч нь Бодь интернэшнл), Эрэл, Фортуна групп, Бридж групп, Залуу монгол, Буян, Оюуны ундраа гэх мэт компаниудыг энд нэрлэж болно. Бизнесийн хүрээний гишүүд үндсэндээ Эх орон-Ардчилал эвслийн бүлгийн гишүүд боловч гэр бүлийн гишүүдээрээ дамжуулан томоохон пүүс компани эзэмшдэг МАХН-ын гишүүд бас бий. Бизнесээс гаралтай эдгээр гишүүд УИХ-ын Эдийн засаг, Төсөв, Байгаль орчны болон Хөдөөгийн хөгжлийн байнгын хороодод түлхүү ажилладаг ба тэд нийт гишүүдийн 31%-ийг эзэлж байна¹.

УИХ дахь бизнесийн төлөөлөл эргэлзээгүй улс төр дэх шинэ дүр төрх мөн. Эдгээр бизнесмэн гишүүд олон жил улс төрөөс ангид байж, өөрсдийн компаниа хууль тогтоох ажиллагаанаас үл хамааран эдийн засгийн харьцангуй либерал нөхцөлд хөгжүүлж чадсан юм. Тэгвэл одоо эдгээр том компаниуд эдийн засгийн үйл ажиллагаагаа улам идэвхжүүлэхийн тулд өөрт ашигтай эрх зүйн орчныг хөгжүүлэх хүсэл сонирхолдоо очсон цаг нь ирсэн ажээ. Үүний шалтгаан нь тэд хууль тогтоомжийн эдийн засгийн ач холбогдлыг ойлгох болсон, эсвэл бүтээгдэж буй уг хуулиуд нь Монголын амьдралын онцлогийг зөвхөн өөрийнхөөрөө мэддэг гадаадын зөвлөхүүдийн тусламжтайгаар хийгдэж буйтай холбоотой байж болох юм. Зарим гишүүдийн хувьд тэртээ тэргүй багтаамж муу өөрийнх нь дотоод зах зээлийг улам эзэлсээр байгаа гадаадын

¹ Б. Гарди: Бизнесмэн+УИХ-ын гишүүн?, Зууны Мэдээ, 2004.08.26.

(тухайлбал хятадын) бизнес өрсөлдөгчдөөс өөрийн компаниа хамгаалахын тулд хууль тогтоох ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч буй аспект байж болох талтай.

Дүгнэлт

АН-д ойр Сант Марал Сан 2004 оны 11 сарын 23-нд улс төрийн тухай олон нийтийн шинэ судалгаа явуулсан юм. Хэрэв маргааш УИХ-ын сонгууль болбол аль намд Та саналаа өгөх вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын нийт буюу улсын хэмжээнд 43% нь (хөдөө 45%, Улаанбаатар 41%) МАХН-д, 28% (хөдөө 45%, Улаанбаатар 25%) нь АН-д саналаа өгөхөөр хариулжээ. Сонгуулийн өмнөх урьдчилсан танадалт болон сонгуулийн дүнг авч үзвэл 11-р сарын судалгааны дээрх дүнд ямар ч гэсэн бодууштай зүйл ажиглагдаж байна.

Энэ удаагийн УИХ-ын сонгууль хэдийгээр улс төрийн намуудын хэцүүхэн арга мэх, залуу ардчилсан тогтолцоон дахь олон "нялхсын өвчин"-ий дунд явагдсан ч Монголын иргэд ардчилал, эрх чөлөөний төлөө эргэлт буцалтгүй зогсож буйг дахин нотлон харуулсан юм. Хэрэв улс төрийн гол өрсөлдөгчид болох МАХН, "Эх орон-Ардчилал" эвслийн хамтарсан Их эвслийн Засгийн газар өнгөрсөн Засгийн газрын эргэлзээгүй эерэг үр дүнг хадгалан тогтвортой бөгөөд харилцан итгэлцлээр ажиллаж чадах юм бол Монгол улс олон орнуудад ардчиллыг бодит амьдрал болгон хэрэгжүүлж буйн сургамжийг өгч чадах болно.

Abstract: The author continued with the present article his research publications on the subject of the history of the democratic process in Mongolia since 1990 (see Political Parties and the Democratic Process in Mongolia, in Mongolische Erkundungen 12(2003), pp. 24-43) The present article is concerning with the parliamentary election in 2004. On the basis of analyzing the successful work of the last MPRP-government (2000-2004) and showing some external influences on the election in 2004 the author concentrates his attention on the relationship between the MPRP and the parties of the political opposition in the first part of his article. He showed that the process of formation of the newer parties is not finished yet because of logistical and problems with the political self-understanding in these parties. The MRPP on the other hand was able to stabilize itself.

In the second part of his article the author is concerning with the political views among the people before the election. He describes the role of methods of political rating in press mass medias first used in Mongolian history and how the election was prepared on the basis of the law of the election to the parliament.

The author made the conclusion that the Mongolians have fully accepted the democratic system. The continued functioning of this system will depend largely on whether the MPRP and the Democratic Party can cooperate in the new coalition government.

Ном зүй

1. 2002.11.20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл. 44 (281) 2002., х. 1324-1327
2. 2002.06.27-ны өдөр батлагдсан Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль. Үнэн. 2002.08.14
3. 2001.06.14-ны өдөр батлагдсан Бүсчилсэн хөгжлийн тухай УИХ-ын тогтоол. Зууны мэдээ. 2001.07.25
4. Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги. Төрийн мэдээлэл. 2003.06.30, х. 571-605
5. 2003.05.30-ны Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл 23 (308) 2003. х. 543-549
6. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, УБ., 1992

7. Улсын Их Хурлын тогтоол. Өдрийн сонин. 2004.04.09
8. Ардчилсан намын түүхэн товчоон, АН-ын удирдлагын баримт, УБ., 2004
9. Barkmann U.B. Politische Parteien und demokratischer Prozess in der Mongolei, in Mongolische Notizen- Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft e. V. 12(2003). S. 24-43
10. Баркманн У.Б. Монголд гурав дахь түнш хэрэгтэй юу? Түүхэн сургамж ба эдүгээ үе. У.Б.Баркманн, Л.Хайсандай, Монгол-Германы харилцаа. УБ., 2004 х. 214-219
11. Батхишиг Б. Ерөнхийлөгчөөс өөрөөс нь асуучихаагүйг харамсаж байна. Зууны мэдээ. 2004.01.14
12. Буянгийн Жагаа шүүхэд хандав. Зууны мэдээ. 2003.10.31
13. Бямбажаргал Л. Би МСДН-ыг сэргээх ажилд идэвхитэй оролцож байна. Зууны мэдээ. 2003.10.30
14. Гарав Г. Ерөнхийлөгчийн байр суурь гайхал төрүүлэх боллоо. Үнэн. 2004.01.14
15. Гарди Б. Бизнесмэн+УИХ-ын гишүүн? Зууны мэдээ. 2004.08.26
16. Дарангуйлагч. Өдрийн сонин. 2000.06.25
17. Зууны мэдээ. 2004.03.25
18. Зууны мэдээ. 2004.04.13
19. Зууны мэдээ. 2004.04.15
20. Зууны мэдээ. 2004.05.19
21. ИЗБНН-ын сонгуулийн хуулийн төсөлд саналаа нэмэрлэв. Зууны мэдээ. 2004.01.03
22. Монгол Улсыг АНУ-д аль аль хэдийн таньжээ. Үнэн. 2001.11.23
23. Монгол Улсын үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд (1924-1992). УБ., 1998, х. 96
24. Нийслэлийн МАХН-ын хяналтын хорооны тогтоол. Үнэн. 2004.05.13
25. Нэрээ эргүүлэн татлаа. Зууны мэдээ. 2004.06.19
26. Отгонбаяр Г. Монголчууд гарман дээр морио юүлдэггүй. Зууны мэдээ. 2002.10.23
27. Д.Оюунхоролыг МАХН-аас хаслаа. Үнэн. 2003.05.22
28. Өдрийн сонин. 2004.04.09
29. Өнөөдөр. 2004.04.07
30. Пүрэв Жав. Элсэгчид нь залуужиж, эгнээгээ тэлж байна. Үнэн. 2004.03.01
31. Sant Maral Foundation, Politbarometer, 21 March 2004, 22, Juni 2004; Зууны мэдээ. 2004.04.14
32. Сонгуулийн кампанит ажлын санхүүжүүлэлтийн мониторинг төслийн явцын тайлан. УБ., 2004.06.08
33. Сонгуулийн хуульд ямар өөрчлөлт оруулах вэ?, Зууны мэдээ. 2004.05.01
34. Социалист Интернационал ба Монгол Ардын Хувьсгалт Нам, Үнэн. 2003.12.16
35. Социалист Интернационал ба Монгол Ардын Хувьсгалт Нам, Үнэн. 2003.12.16
36. Сэтгүүлчид сонгуулийн үеэр баримтлах зарчмаа тохиров. Зууны Мэдээ. 2004.04.15
37. Төрийн өмчийг 2004 онд хувьчлах хөтөлбөрийг баталлаа. Зууны Мэдээ. 2004.01.14
38. Тунгалаг Д., Цэрэнпил Д. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал. УБ., 2002. х.133
39. Түвшин Б. МАХН рейтингээрээ тэргүүлж байна. Зууны мэдээ. 2004.06.19
40. Улсын Их Хурлын 2004 оны тойргийн хорооны бүрэлдэхүүн, Зууны мэдээ. 2004.04.27

41. Хандивлагчид Засгийн газрын үйл ажиллагаа, хичээл зүтгэлийг үнэлж байна.
42. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Зууны мэдээ. 2004.01.22
43. Чинбилиг Б. МАХН бүл нэмлээ. Үнэн. 2004.02.03
44. Чулуун Ч. УИХ-ын сонгуульд 339 хүний нэр дэвшсэнээс 262-ыг нь бүртгэжээ. Өдрийн сонин. 2004.06.01
45. Эвслийнхэн Ерөнхийлөгчийн хэлсэн үгийг уриа дуудлагаа болгон ашиглаж эхэллээ. Үнэн. 2004.01.27
46. Эмүжин Р. Наймаа ба улс төр. Өнөөдөр. 2004.05.13
47. Эх орон-Ардчилал эвслийн дүрэм. УБ., 2003
48. Эх орон-Ардчилал эвсэл тойргуудаа эцэлсэн тохирлоо. Өдрийн сонин. 2004.05.13
49. Ядамсүрэн Ж. Сонгогч бүрийн санал төрд хэрэгтэй. Өдрийн сонин. 2004.04.27